



σ

БАТЛАВ. МОНГОЛ ШУУДАН ХК-НИЙ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б. АНХБААТАР



**“ШАТАХУУН НИЙЛҮҮЛЭХ” ГҮЙЦЭТГЭГЧИЙГ
СОНГОН ШАЛГАРУУЛАХ ХЯЗГААРЛАГДМАЛ
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендер шалгаруулалт/ гэрээний нэр, дугаар:

“Шатахуун нийлүүлэх” гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, МШ/201901130”

Улаанбаатар хот

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

ГАРЧИГ

A. Еронхий зүйл

1. Тендерийн цар хүрээ
2. Санхүүжилтийн эх үүсвэр
3. Залилан мэхлэх болон авилгын үйлдэл
4. Эрх бүхий тендерт оролцогч
5. Эрх бүхий бараа
6. Түншлэл

B. Тендерийн баримт бичиг

7. Тендерийн баримт бичгийн агуулга
8. Тендерийн баримт бичгийг тодруулах
9. Тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах

B. Тендер бэлтгэх

10. Тендер шалгаруулалтад оролцох зардал
11. Тендерийн хэл
12. Тендерийн иж бүрдэл
13. Тендерийн маягт болон үнийн хуваарь
14. Хувилбарт тендер
15. Тендерийн үнэ болон үнийн хөнгөлөлт
16. Тендерийн валют
17. Тендерт оролцогч эрх бүхий эсэхийг нотлох баримт
18. Тендерт оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг нотлох баримт
19. Нийлүүлэх бараа нь тендерийн баримт бичигт нийцэж буйг нотлох баримт
20. Тендер хүчинтэй байх хугацаа
21. Тендерийн баталгаа
22. Тендер ирүүлэх хувь, тендерт гарын үсэг зурах

Г. Тендер ирүүлэх

23. Тендерийг битүүмжлэх, бичиглэл хийх
24. Тендер хүлээн авах эцсийн хугацаа
25. Хугацаа хоцорсон тендер
26. Тендерт оролцогч нэг этгээд нэг тендер ирүүлэх

27. Тендерт нэмэлт өөрчлөлт хийх, тендерийг буцааж авах

Д. Тендерийг нээх, үнэлэх

28. Тендерийг нээх
29. Нууцлал
30. Тендерийн тодруулга
31. Тендерийг хянан үзэх, шаардлагад нийцэх эсэхийг тогтоох
32. Алдааг залруулах
33. Нэг валютэд хөрвүүлэх
34. Дотоодын тендерт оролцогчид давуу эрхийн зөрүү тооцох
35. Тендерийг үнэлэх, харьцуулах
36. Тендерт оролцогчийн чадварыг дахин магадлах
37. Аливаа тендерийг сонгох, эсвэл тендерүүдээс татгалзах захиалагчийн эрх

E. Гэрээ байгуулах эрх олгох

38. Гэрээ байгуулах эрх олгох шалгуур

39. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
40. Захиалагч гэрээ байгуулах эрх олгох үед тоо хэмжээг өөрчлөх
41. Гэрээнд гарын үсэг зурах
42. Гүйцэтгэлийн баталгаа

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

A. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1. Тендерийн цар хүрээ	<ol style="list-style-type: none">1.1. Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт (цаашид ТШӨХ гэж товчлох)-д тодорхойлсон захиалагч (цаашид “захиалагч” гэх) нь энэ тендерийн баримт бичгийн ТШӨХ болон техникийн тодорхойлолтод заасан бараа, материал болон тоног төхөөрөмж (цаашид “бараа” гэх) худалдан авах тухай гэрээ байгуулахаар энэхүү тендер шалгаруулалтыг зохион байгуулж байна.1.2. Тендер шалгаруулалт нь ТШӨХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд нэг багцтай байна.1.3. Олон багцтай тендер шалгаруулалтын тендерийн баримт бичгийг багц тус бүрээр үнэлж зарахыг хориглоно.1.4. Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь техникийн тодорхойлолтод нийцсэн барааг бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан хугацаанд, газарт хүргэх үүрэгтэй.
2. Санхүүжилтийн эх үүсвэр	<ol style="list-style-type: none">2.1. Захиалагч дээр дурдсан барааг ТШӨХ-д тодорхойлсон эх үүсвэрээр санхүүжүүлнэ.
3. Залилан мэхлэх болон авлигын үйлдэл	<ol style="list-style-type: none">3.1. Төрийн албан хаагч болон тендерт оролцогч, гэрээ хэрэгжүүлэгч бүр худалдан авах ажиллагаанд оролцожгэрээг хэрэгжүүлэхдээ ёс суртахууны өндөр хэмжээг сахин биелүүлэх ёстай.3.2. Худалдан авах ажиллагаанд оролцож байгаа төрийн албан хаагч болон тендерт оролцогч нь Авлигын эсрэг хууль, Шударга бус өрсөлдөөний хориглох тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан авлигын, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлан сурдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон талаар бодитой мэдээлэл байгаа бол холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад зохих ёсоор мэдэгдэх үүрэгтэй.
4. Эрх бүхий тендерт оролцогч	<ol style="list-style-type: none">4.1. Тендерийн урилга нь сонирхосон этгээд бүрт нээлттэй. хуулийн⁹ дүгээр 9.3 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд тендерт оролцогч болон түүний түншлэлийн гишүүн бүр нь аль ч улсын харьяалалтай байж болно.4.2. Дараах тохиолдолд тендерт оролцогч (түншлэлийн гишүүн бүрт нэгэн адил хамаарна)-ийг эрх бүхий бус гэж үзнэ. Үүнд:<ol style="list-style-type: none">4.2.1. Төлбөрийн чадваргүй болсон, татан буугдаж байгаа, дампуурулаас зайлсхийх зорилгоор зээлдүүлэгчтэй тохиролцсон, бизнесийн үйл ажиллагааг нь зогсоосон, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу дээр дурдсантай адилтгах нөхцөлд байгаа;4.2.2. Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлөөгүй;4.2.3. Төрийн өмчйт болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь бүтэц, зохион байгуулалт болон санхүүгийн хувьд

захиалагчаас хараат байдлаар үйл ажиллагаа явуулдаг бол;

- 4.2.4. Сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлэгүй, эсхүл мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасныг шүүх, эрх бүхий байгууллага тогтоосон;
- 4.2.5. Тендерт оролцогч (туслан гүйцэтгэгч бүрийг оролцуулан) нь бараа, ажил, үйлчилгээний зураг төсөл, техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээдтэй нэгдмэл сонирхолтой;
- 4.2.6. Илт худал мэдээлэл бүхий тендер ирүүлснийг эрх бүхий байгууллага тогтоосон;
- 4.2.7. Сүүлийн 3 жилийн хугацаанд Авлигын эсрэг хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан авлигын, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлан сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон болохыг шүүх тогтоосон;
- 4.2.8. Энэхүү тендер шалгаруулалтад оролцож байгаа хоёр буюу түүнээс дээш тооны тендерт оролцогчийн хууль ёсны төлөөлөгч нь нэг этгээд бол;
- 4.2.9. Энэхүү тендерийн баримт бичгийн ТОӨЗ-ны 14 дүгээр зүйлд хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрснөөс бусад тохиолдолд тендерт оролцогч нэгээс дээш тендер ирүүлсэн бол;(Гэвч энэхүү заалт нь аливаа этгээдийг нэгээс дээш тендерт туслан гүйцэтгэгчээр оролцохыг, эсхүл нэг тендер шалгаруулалтад нэгээс олон багцад тендер ирүүлэхийг хязгаарлахгүй)
- 4.3. Тендерт оролцогч 4.2.1 - 4.2.9-д дурдсан нөхцөл үүссэн эсэх тухай мэдэгдлийг захиалагчид бичгээр гаргаж өгөх үүрэгтэй. Эдгээр нөхцөл үүссэн эсэхийг магадлах зорилгоор захиалагчаас тавьсан шаардлагын дагуу тендерт оролцогч холбогдох баримт, нотолгоог захиалагчид ирүүлнэ.

5. Эрх бүхий бараа

- 5.1. Гэрээгээр нийлүүлэх бараа нь аль ч улсын гарал үүсэлтэй байж болно. Захиалагч төлбөрийг зөвхөн ТОӨЗ-ны 1.1-д дурдсан барааг хүлээн авснаар төлнө.
- 5.2. Энэхүү зааварчилгааны 5.1-д дурдсан барааны гарал үүсэл гэдэгт тухайн барааг олборлосон, ургуулсан, бойжуулсан, эсхүл хийж бүтээсэн улс орон буюу газар нутгийг хэлнэ. Хийж бүтээсэн гэж үйлдвэрлэсэн, боловсруулсан, эсхүл эд ангиудын дийлэнхийг угсарч, энэ эд ангиудын үндсэн шинж чанар, зориулалт, эсхүл ашиглалтын хэлбэрээс илт өөр арилжааны шинэ бараа гаргаж ирэхийг хэлнэ.

6. Түншлэл

- 6.1. Хоёр ба түүнээс дээш тооны хуулийн этгээд хамтран ажиллах гэрээний үндсэн дээр нэг тендерт оролцогч /цаашид талуудыг хамтад нь “түншлэл”, тус бүрийг нь “түншлэлийн гишүүн” гэх/ болж тендер ирүүлэх тохиолдолд ТШӨХ-дөөрөөр заагаагүй бол дараах шаардлагыг хангасан байна. Үнд:
- (а) түншлэлийн бүх гишүүний хувьд тендер хүчин төгөлдөр байхаар тендерт гарын үсэг зурсан байх;
- (б) ТОӨЗ-ны 1.1-д заасан бараа нийлүүлэх гэрээг хэрэгжүүлэхэд бүх гишүүн хамтран болон тус тусдаа хүлээн хариуцлагыг тодорхойлж хамтран ажиллах гэрээнд тодорхойлсонбайх;
- (в) түншлэлийн аль нэг болон бүх гишүүний нэрийн өмнөөс үүрэг хүлээн, зааварчилгаа хүлээн авахад тэдгээрийг төлөөлөх эрх бүхий

нэг гишүүн томилох;

- (г) нийт гэрээний гүйцэтгэл, түүний дотор төлбөр тооцоогзөвхөн төлөөлөх эрх бүхий гишүүнтэй харилцаж, гүйцэтгэх тухайхамтран ажиллах гэрээгээр зохицуулсан байх;
- (д) түншлэлийн гэрээний хувийг тендерийн хамт ирүүлэх.

Б. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

7. Тендерийн баримт бичгийн агуулга

- 7.1. Тендерийн баримт бичиг нь дор дурдсан бүлгүүдийг агуулсан 3 хэсэг баримт бичиг болон ТОӨЗ-ны 9 дүгээр зүйлийн дагуу хийсэн нэмэлт өөрчлөлтөөс бүрдэнэ. Үүнд:

I ХЭСЭГ

- Бүлэг 1. Тендерт оролцогчид өгөх зааварчилгаа
Бүлэг 2. Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт
Бүлэг 3 Тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт
Бүлэг 4. Тендер шалгаруулалтын маягт
 - Тендерийн маягт
 - Үнийн хуваарь
 - Тендерийн баталгааны маягт
 - Үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн зөвшөөрлийн маягт

II ХЭСЭГ

- Бүлэг 5. Бараа нийлүүлэлтэд тавигдах шаардлага, техникийн тодорхойлолт

III ХЭСЭГ

- Бүлэг 6. Гэрээний ерөнхий нөхцөл
Бүлэг 7. Гэрээний тусгай нөхцөл
Бүлэг 8. Гэрээний маягт
 - Гэрээний маягт
 - Гүйцэтгэлийн баталгааны маягт
 - Урьдчилгаа төлбөрийн баталгааны маягт

Хавсралт: Тендерийн урилга

- 7.2. Захиалагчийн нийтэлсэн тендерийн урилга нь тендерийн баримт бичгийн хэсэг болохгүй.
- 7.3. Тендерт оролцогч тендерийн баримт бичиг дэх бүх зааварчилгаа, нөхцөл, маягт болон техникийн тодорхойлолтыг нягталж үзэх нь зүйтэй. Тендерийн баримт бичигт шаардсан мэдээлэл, баримт материалыг ирүүлэхгүй байх, маягтыг дутуу бөглөн ирүүлэх нь тухайн тендерээс татгалзах үндэслэл болж болно.

8. Тендерийн баримт бичгийг тодруулах

- 8.1. Тендерт оролцохыг сонирхогч нь тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах шаардлагатай бол энэ тухай хүсэлтээ бичгээр гаргаж шуудан, эсхүл утсан холбоо (“утсан холбоо”-нд зөвхөн телекс болон факсыгхамруулна)-гоор ТШӨХ-дзаасан захиалагчийн хаягаар ирүүлнэ. Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ТШӨХ-д заасан хоногийн өмнө хүлээн авсан хүсэлтэд хариу өгнө. Хүсэлтийн агуулга, түүнд өгөх захиалагчийн хариуг хүсэлтийн эх сурвалжийг дурдалгуйгээр тендерийн баримт бичиг худалдан авсан бүх тендерт оролцогчид бичгээр гаргаж шуудан, эсхүл утсан холбоогоор нэгэн зэрэг мэдэгдэнэ.

- 8.2. Тухайн тодруулгын үр дүнд захиалагч тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулахшаардлагатай гэж үзвэл энэхүү ТОӨЗ-ны 9дүгээр зүйл, 24.2 дахь хэсэгт заасан журмыг баримтална.
- 9. Тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах**
- 9.1. Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулж болно.
- 9.2. Ийнхүү оруулсан аливаа нэмэлт өөрчлөлт нь тендерийн баримт бичгийн салшгүй хэсэг болох бөгөөд тендерийн баримт бичиг худалдан авсан бүх тендерт оролцогчид бичгээр гаргаж шуудан, эсхүл утсан холбоогоор нэгэн зэрэг мэдэгдэнэ. Тендерт оролцогч нэмэлт өөрчлөлт тус бүрийг хүлээн авсан тухайгаа захиалагчид утсан холбоогоор мэдэгдэх үүрэгтэй.
- 9.3. Тендерийн баримт бичигт орсон нэмэлт, өөрчлөлтийн улмаас тендер зайлшгүй өөрчлөгдхөн ба уг өөрчлөлтийг бэлтгэхэд шаардагдах хангалттай хугацаа тендерт оролцогчид олгох шаардлагатай гэж үзвэл захиалагч 24.2-т заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгаж болно.

B. ТЕНДЕР БЭЛТГЭХ

- 10. Тендер шалгаруулалтад оролцох зардал**
- 10.1. Тендерт оролцогч тендер бэлтгэх, захиалагчид ирүүлэхтэй холбогдон гарах бүх зардлыг өөрөө бүрэн хариуцах бөгөөд захиалагч ямар ч нөхцөлд энэхүү зардалтай холбогдох хариуцлага хүлээхгүй.
- 11. Тендерийн хэл**
- 11.1. Тендер, түүнчлэн тендертэй холбоотойгоор захиалагч тендерт оролцогчийн хооронд харилцаж буй албан бичиг, захиалууд болон бусад баримт материалыг тендерт оролцогчид өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэх ба холбогдох бүх баримт бичиг нь монгол хэл дээр, гадаадын этгээд худалдан авах ажиллагаанд оролцох эрхтэй бол тэдгээр нь ТШӨХ-д заасан хэл дээр байна. Тендерийн баримт бичгийн монгол хэл дээрх хувь гадаад хэл дээрхтэй зөрчилдөл монгол хэл дээр бэлтгэсэн ТББ-ийн заалтыг баримтална.
- 11.2. Аливаа тендерийг дагалдах баримт бичиг, хэвлэмэл материал нь өөр хэл дээр байж болох бөгөөд энэ тохиолдолд тэдгээрийн тендерт холбогдох хэсгийг ТОӨЗ-ны 11.1-д заасан хэл рүү хөрвүүлсэн орчуулгыг тендерт оролцогч давхар бэлтгэж ирүүлэх бөгөөд уг орчуулгыг тендерийг хянан үзэх, үнэлэхэд харгалзана.
- 12. Тендерийн иж бүрдэл**
- 12.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлэс бүрдэнэ. Үүнд:
- (а) ТОӨЗ-ны 13, 15 дугаар зүйлд заасны дагуу бэлтгэсэн тендерийн маягт болон үнийн хуваар;
 - (б) захиалагч шаардсан бол ТОӨЗ-ны 21 дүгээр зүйлд заасны дагуу ирүүлэх тендерийн баталгаа;
 - (в) тендерт оролцогчийг төлөөлж ТОӨЗ-ны 22 дугаар зүйлд заасны дагуу тендерт гарын үсэг зурах этгээдийн гарын үсгийг баталгаажуулж гаргасан итгэмжлэл;
 - (г) тендерт оролцогчийг тухайн тендерт оролцох эрх бүхий гэдгийг тогтооход шаардлагатай ТОӨЗ-ны 17 дугаар зүйлд заасан нотлох баримтууд;
 - (д) тендерт оролцогч нь тухайн гэрээг хэрэгжүүлэх чадвартай болохыг тогтооход шаардлагатай ТОӨЗ-ны 18 дугаар зүйлд

заасан нотлох баримтууд;

(e) нийлүүлэх бараа болон түүнийг дагалдах үйлчилгээ нь тендерийн баримт бичигт нийцэж буйг баталгаажуулсан ТОӨЗ-ны 19 дүгээр зүйлд заасан нотлох баримт;

(ё) ТШӨХ-д шаардсан ТОӨЗ-ны дагуу бэлтгэж ирүүлэхбусад материалы.

13. Тендерийн маягт болон үнийн хуваарь

13.1. Тендерт оролцогч нь Бүлэг 4-т заасан тендерийн маягтыг бөглөж ирүүлнэ. Энэхүү маягтыг бөглөхдөө түүний агуулгыг өөрчлөлгүйгээр түүнд шаардсан бүх мэдээллийг тусгана.

13.2. Тендерт оролцогч нь нийлүүлэх бараа болон түүнийг дагалдах үйлчилгээний үнийн хуваарийг бэлтгэн ирүүлнэ. Үнийн хуваарийг 4 дүгээр бүлэгт заасан тендер шалгаруулалтын маягтаас тохирох маягтыг ашиглан бэлтгэнэ.

14. Хувилбарт тендер

14.1. ТШӨХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд тендерт оролцогч тендерийн баримт бичгийн шаардлагад нийцсэн зөвхөн нэг тендер ирүүлэх ба хувилбарт тендер ирүүлэхийг үл зөвшөөрнө.

15. Тендерийн үнэ болон үнийн хөнгөлөлт

15.1. Тендерийн маягт болон үнийн хуваарь дахь тендерт оролцогчийн санал болгож буйүнэ болон, үнийн хөнгөлөлт нь дор тодорхойлсон шаардлагад нийцсэн байна.

15.2. Үнийн хуваарыт бүх багц болон нэр төрлийг үнэ тус бүрээр нь тусад нь жагсааж ирүүлнэ.

15.3. Тендерийн маягтад тусгасан үнэ нь аливаа үнийн хөнгөлөлтийг тооцоогүй тухайн тендерийн нийт үнэ байна.

15.4. Тендерт оролцогч нь аливаа нөхцөлт бус үнийн хөнгөлөлт болон түүнийг хэрэглэх аргачлалыг тендер ирүүлэх маягтад тусад нь тусгасан байна.

15.5. Олон улсын худалдааны EXW, CIP болон ижил төстэй бусад нөхцөлийг хэрэглэхдээ ТШӨХ-д дурдсан, Олон улсын худалдааны танхимаас эрхэлэн гаргасан Incoterms-ийн хамгийн сүүлийн хувилбарыг удирдлага болгоно.

15.6. Нийлүүлэх барааны үнийг тендерийн маягт (Бүлэг 4)-д заасан үнийн хуваарь бүрээр гаргаж ирүүлнэ. Ингэхдээ тендерт оролцогч нь гэрээний дагуу нийлүүлэх барааны нэгж үнэ, тухайн нэр төрлийн нийт үнэ, нийт дүн, барааны гарал үүслийн улсын нэрийг бараа нийлүүлэлтийн хуваарыт заасан нэр төрөл бүрээр холбогдох үнийн хуваарыт тусгаж ирүүлнэ. Үнийн задаргааны агуулга нь захиалагчаас тендерийг харьцуулж үнэлэх зорилгоор шаардагдана. Энэ нь санал болгосон аливаа нөхцөлөөр гэрээ байгуулах захиалагчийн эрхийг хязгаарлахгүй.

15.7. Гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар хураамжийг тендер хүлээж авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийг үндэслэн тендерийн үнэд багтаасан байна.

15.8. Барааг багцалсан эсэх талаарх мэдээллийг ТОӨЗ-ны 1.2 дахь заалт болон түүнд харгалзах ТШӨХ-ийн заалтаасүзнэ үү. Хэрэв багцалсан бол тендерт оролцогч нэг, эсхүл түүнээс олон багцад тендер ирүүлэх эрхтэй. Аливаа багцыг хувааж дэд багц болгон тендер ирүүлэхийг хориглоно.

15.9. Үнийн хуваарыт дараах зүйлсийг тусад нь бичиж харуулна. Үүнд:

- (а) Монгол Улсад үйлдвэрлэгдсэн барааны хувьд:
1. барааны EXW үнэ (үйлдвэрийн, агуулахын, эсхүл лангууны үнийн аль тохирохыг). Энэ үнэд барааг үйлдвэрлэх, угсрахад ашигласан үйлдвэрийн, эсхүл лангууны үнээр үнэлэгдсэн эд анги, түүхий эд, үйлдвэрлэлийн бусад өртөг багтана;
 2. гэрээ байгуулах эрх олгогдсоноор дотоодын бүтээгдэхүүнд ногдуулдаг нэмэгдсэн өргтийн болон бусад адилтгах албан татвар;
 3. барааг ТШӨХ-д заасан эцсийн цэгт хүргэхэд шаардлагатай хуурай газрын тээвэр, даатгал болон дотоодод гарах бусад зардал.
- (б) Монгол Улсын гадна үйлдвэрлэгдсэн бөгөөд импортоор орж ирэх барааны хувьд:
1. ТШӨХ-д захиалагчийн нэрлэсэн хилийн боомт хүртэлх СИФ/CIF/ үнэ, эсхүл захиалагчийн нутаг дэвсгэр дэхь нэрлэсэн байрлал хүртэлх СИП /CIP/ үнэ;
 2. гэрээ байгуулах эрх олгогдсоноор импортоор орж ирэх бараанд ногдох гаалийн, нэмэгдсэн өргтийн болон бусад албан татвар;
 3. барааг орох боомтоос буюу нэрлэсэн байрлалаас ТШӨХ-д заасан эцсийн цэгт хүргэхэд шаардагдах хуурай газрын тээвэр, даатгал болон дотоодод гарах бусад зардал.
- (в) Монгол Улсын гадна үйлдвэрлэгдсэн бөгөөд өмнө нь импортоор орж ирсэн барааны хувьд:
1. барааны үнэ буюу импортоор анх орж ирсэн тухайн барааны үнэ дээр үнийн нэмэгдэл/эсхүл хөнгөлөлт/, дотоодод гарсан аливаа нэмэлт өртөг, тухайн бараанд төлсөн эсхүл төлөгдөх гаалийн болон импортын бусад татваруудыг тооцсон үнэ;
 2. импортлогдсон бараанд урьд төлсөн(нотлох баримтыг хамт ирүүлэх шаардлагатай), эсхүл төлөгдөх гаалийн болон импортын бусад татварууд;
 3. тухайн барааг олж авахад зарцуулсан өртөг буюу энэ заалтын 1 болон 2 –ын ялгавар;
 4. гэрээ байгуулах эрх олгогдсоноор импортоор орж ирсэн бараанд ногдох нэмэгдсэн өргтийн болон бусад албан татвар;
 5. барааг ТШӨХ-д заасан эцсийн цэгт хүргэхэд шаардлагатай хуурай газрын тээвэр, даатгал болон дотоодод гарах бусад зардал.
- (г) Барааны Техникийн тодорхойлолт болон холбогдох үйлчилгээний талаарх шаардлагад тодорхойлсон Дагалдах үйлчилгээний хувьд:

Гэрээ байгуулах эрх олгогдсоноор Дагалдах үйлчилгээнд ногдох Худалдан авагч орны гаалийн, худалдааны болон бусад адилтгах албан татварыг тооцож

- (1) Дагалдах үйлчилгээг бүрдүүлж буй зүйл тус бүрийн дотоодын валютаар илэрхийлэгдэх зардлын өртөг;
- (2) Дагалдах үйлчилгээг бүрдүүлж буй зүйл тус бүрийн гадаадын валютаар илэрхийлэгдэх зардлын өргтийг тус тус харуулна.

- 15.10. ТШӨХ-д гэрээний үнийг тохируулах нөхцөлтэй байхаар тусгайлан зааснаас бусад тохиолдолд тендерт оролцгчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байна. Тендерийн үнийг гэрээний хэрэгжилтийн явцад тохируулж өөрчлөхөөр санал болгосон аливаа тендерийг ТОӨЗ-ны 31 дүгээр зүйлд заасны дагуу үндсэн шаардлага хангагүй тендер гэж үзэж, уг тендерээс татгалзана. Гэвч ТШӨХ-д үнэ тохироулахаар заасан нөхцөлд тогтмол үнэ санал болгосон тендерээс татгалзахгүй бөгөөд түүний үнийн тохироулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэг (0)-тэй тэнцүү байна гэж үзнэ.
- 15.11. ТШӨХ-д үнэ тохироулахаар заасан бол үнэ тохироулах нөхцөл, аргачлалыг гэрээний тусгай нөхцөлд тусгана.
- 15.12. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлт үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.
- 16. Тендерийн валиот**
- 16.1. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2 дахь хэсэгт заасны дагуу тендерийн үндсэн валиот нь төгрөг байна.
- 17. Тендерт оролцогч эрх бүхий эсэхийг нотлох баримт**
- 17.1. Тендерт оролцогч нь эрх бүхий эсэхийг дараах мэдээлэл, нотлох баримтад үндэслэн тогтооно. Үүнд:
- (а) хуулийн этгээдийн бүртгүүлсэн газар, бизнесийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, хаягийг тодорхойлсон улсын бүртгэлийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбар,
 - (б) тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл;
 - (в) ТШӨХ-д шаардсан бол тухайн төрлийн бараа нийлүүлэх тусгай зөвшөөрөл.
- 18. Тендерт оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг нотлох баримт**
- 18.1. Тендерт оролцогч нь гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан захиалагчийн шаардсан чадварын шаардлагыг хангасан гэдгийг харуулах дараах мэдээллийг нотлох баримт болгон ирүүлнэ. Үүнд:
- (а) хэрэв ТШӨХ-д шаардсан бол тендерт оролцогч өөрөө үйлдвэрлэгүй барааг тендерт санал болгох тохиолдолд уг барааг Монгол Улсад нийлүүлэх эрх олгосон тухай үйлдвэрлэгчийн зөвшөөрлийг 4 дүгээр бүлгийнмаягтаас тохирох маягтыг ашиглан ирүүлнэ;
 - (б) санхүүгийн чадавхийг харуулах ТШӨХ-д заасан тоо бүхий жилийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан;
 - (в) гэрээг хэрэгжүүлэх удирдах болон техникийн голлох боловсон хүчиний чадвар, туршлагын талаарх мэдээлэл;
 - (г) тухайн тендерт оролцогчийн туршлагыг харуулах сүүлийн [ТШӨХ-д заасан тоо] жилийн хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй гэрээний талаарх мэдээлэл;
 - (д) хэрэв ТШӨХ-д шаардсан бол Монгол Улсын нутаг дэвсгэрт бизнесийн үйл ажиллагаа явуулдаггүй тендерт оролцогч гэрээний дагуу хийгдэх засвар үйлчилгээ, техникийн тодорхойлолтод заасан сэлбэг хэргслийг нийлүүлэх үргийг Монгол Улсын нутаг дэвсгэрт тухайн этгээд өөрөө гүйцэтгэх, эсхүл уг тендерт оролцогчийн Монгол Улсад байгуулсан, эсхүл байгуулагдах төлөөлөгч биелүүлэх тухай баримт;
 - (е) захиалагч тендерт оролцогчийн харилцагч банкнаас тодорхойлолт

хүсэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн мэдэгдэл;

- (ө) одоогийн ба сүүлийн [ТШӨХ-д заасан тоо] жилийн хугацаанд тендерт оролцогчийн оролцсон аливаа шүүхийн зарга, маргааны талаарх мэдээлэл;
- (ж) гэрээний үнийн 10-аас дээш хувьтай тэнцэх дүнтэй ажлыг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэх бол түүний чадварын талаарх мэдээлэл.

18.2. Тендерт оролцогч ТОӨЗ-ны 1.1-д заасан барааг нийлүүлэх гэрээг хэрэгжүүлэхийн тулд дор дурдсан чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангасан байна.Үүнд:

- (а) сүүлийн 5 жилийн аль нэг жилд гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ нь ТШӨХ-д заасан дүнгээс багагүй байх;
- (б) сүүлийн [ТШӨХ-д заасан тоо]жилийн хугацаанд хэрэгжүүлсэн тухайн гэрээтэй ижил төстэй, доод тал нь нэг бараа нийлүүлэх үндсэн гүйцэтгэгчээр ажилласан туршлага;
- (в) ТШӨХ-д заасан үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг цаг хугацаанд нь (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах санал;
- (г) бусад гэрээт ажилд ашиглагдах буюу ашиглаж буй хөрөнгө болон энэ гэрээний дагуу хийгдэж болох урьдчилгаа төлбөрийг оролцуулахгүйгээр түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээл нь ТШӨХ-д дурдсан дүнгээс багагүй байх.
- (д) сүүлийн ТШӨХ-д дурдсан жилийн хугацаанд ашигтай ажилласан байх.

18.3. Тендерт оролцогч түншлэл нь 18.2(а) ба (г)-д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлохын тулд түншлэлийн гишүүн тус бүрийн үзүүлэлтийг хооронд нь нэмнэ. Гэхдээ гишүүн тус бүр 18.2 (а), (б), (г) -д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийн доод тал нь 25 хувийг, төлөөлөх эрх бүхий гишүүн доод тал нь 40 хувийг хангасан байна.

Энэ шаардлагыг биелүүлэгүй тохиолдолд түншлэлийг тухайн чадварын шаардлагуудыг хангаагүй гэж үзэж тендерээс нь татгалзана. ТШӨХ-д өөрөөр заагаагүй тохиолдолд тендерт оролцогч чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлоход түүний туслан гүйцэтгэгчийн ажлын туршлага, нөөц бололцоог харгалзан үзэхгүй.

Тендерт оролцогч 18.2(б) ба (в)-д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлохдоо түншлэлийн гишүүн тус бүрийн үзүүлэлтийг хооронд нь нэмж тооцно.

18.4. ТШӨХ-д тусгайлан заасан бол Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд 10 хувийн давуу эрх олгоно. Монгол Улсын гарал үүсэлтэй бараа нийлүүлэхтендерт оролцогч давуу эрх эдлэх хүүсэлтэй бол энэ тухайгаа нотлоход шаардлагатай баримт, материалыг тендертэй хамтируулэх үүрэгтэй.

19. Нийлүүлэх бараа нь тендерийн баримт бичгийн

19.1. Тендерт оролцогч, түүний нийлүүлэх бараа нь захиалагчийн шаардсан техникийн тодорхойлолт болон стандартад нийцэж буйг нотлох баримтыг тусгайлан бэлтгэж тендерт ирүүлнэ. Нотлох баримт нь нийтлэл, зураг, өгөгдлийн хэлбэрээр байж болох ба дараах мэдээллийг

**шаардлагад
нийцэж буйг
нотлох баримт**

агуулна. Үүнд:

- (а) барааны техникийн болон үйл ажиллагааны шинж чанарын дэлгэрэнгүй тодорхойлолт;
- (б) барааг [ТШӨХ-д заасан тоо] жилийн хугацаанд тасралтгүй, горимын дагуу ажиллуулахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад зүйлсийн жагсаалт. Тус жагсаалтад тэдгээрийг аль улсаас, хаанаас нийлүүлэх боломжтойг, мөн нэгж үнэ зэрэг холбогдох мэдээлийг дурдана;
- (в) нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцэхийг зүйл, заалт бүрээр нотлон харуулсан тайлбар, эсхүл тус тодорхойлолтын аль нэг зүйл, заалтыг орхигдуулсан, зөрсөн боловч захиалагчийн тогтоосон техникийн тодорхойлолтын шаардлагыг үндсэнд нь хангаж байгааг нотолсон мэдэгдэл;
- (г) захиалагчийнтехникийн тодорхойлолтод дурдсан чанар, материал болон тоног төхөөрөмжийн стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаар нь тухайн бараанд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлох бөгөөд түүгээр хязгаарлагдахгүйг тендерт оролцогч анхаарч 19.1.(в)-ийн дагуу тайлбар ирүүлнэ.

Тендерт өөр стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаарыг орлуулан хэрэглэж болох бөгөөд орлуулах зүйл нь техникийн тодорхойлолтод заасантай дүйцэхүйц, эсхүл түүнээс илүү шаардлага хангасан гэдгийг тендерт оролцогч захиалагчид нотлон харуулна.

**20. Тендер
хүчинтэй байх
хугацаа**

20.1. Тендерийн хүчинтэй байх хугацаа нь хуульд заасан хүчинтэй байх хугацаанаас богино байх тохиолдолд захиалагч түүнийг үндсэн шаардлага хангагүй тендер гэж үзэж татгалзана.

**21. Тендерийн
баталгаа**

21.1. ТШӨХ-д шаардсан тохиолдолд тендерт оролцогч нь ТШӨХ-д заасан үнийн дунтэй тэнцэх тендерийн баталгааг ирүүлнэ.

21.2. Тендер шалгаруулалт олон багцтай болнэг тендерийн баталгаа гаргаж, түүнд багц тус бүрээр тодорхойлж ирүүлнэ.

21.3. Захиалагч тендерийн баталгааны хэмжээг багц тус бүрийн төсөвтөргийн 1-2 хувиар тооцож ТШӨХ-д заана.

21.4. Тендерийн баталгаа нь Монгол Улсын, эсхүл гадаадын нэр хүндтэй банкны гаргасан баталгаа, Засгийн газрын бонд эсхүл Засгийн газраас хүлээн зөвшөөрсөн үнэт цаасны хэлбэрээр байж болно. Тендерийн баталгааг 4 дүгээр бүлэг дэх маягтаар, эсхүл тендер хүлээн авахаас өмнө захиалагч урьдчилан хүлээн зөвшөөрсөн маягтаар ирүүлнэ. Тендерийн баталгаа нь тендер хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

21.5. Тендерийн баталгааны эх хувийг ирүүлэхдээ захиалагчийн ТШӨХ-д заасан хоног (он, сар, өдөр)-оор тооцож ирүүлнэ.

21.6. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.

21.7. Энэ зүйлдшаардсаны дагуу хүлээн зөвшөөрөхүйц тендерийн баталгаа ирүүлээгүй аливаа тендерээс захиалагч үндсэн шаардлага хангагүй гэж үзэж татгалзана.

21.8. Тендер нь шалгараагүй оролцогчийн тендерийн баталгааг 20.1-д заасан тендер хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоногт багтаан хүчингүй болгоно.

21.9. Тендер нь шалгарсан оролцгчийн тендерийн баталгааг ТОӨЗ-ны 41 дүгээр зүйлийн дагуу гэрээнд гарын үсэг зурж, ТОӨЗ-ны 42 дүгээр зүйлийн дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлсэн тохиолдолд хүчингүй болгоно.

21.10. Тендерийн баталгааг дараах тохиолдолд улсын орлого болгоно. Үүнд:

- (а) тендер нээсний дараа тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө тендерт оролцогч өөрийн тендерийг буцааж авсан, эсхүл буцааж авахыг бичгээр мэдэгдсэн;
- (б) тендерт оролцогч 32.2-ын дагуу тендерийн үнэд хийсэн залруултыг хүлээн зөвшөөрөгүй бөгөөд ТОӨЗ-ын 38.2-т заасан нөхцөл үүссэн бол;
- (в) шалгарсан тендерт оролцогч заасан хугацаанд багтаан:
 - (1) ТОӨЗ-ны 41 дүгээр зүйлийн дагуу гэрээнд гарын үсэг зураагүй;
 - (2) ТОӨЗ-ны 42 дугаар зүйлийн дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй.

22. Тендер ирүүлэх хувь, тендерт гарын үсэг зурах

22.1. Тендерийн бичиг баримтанд (компьютер, бичгийн машин гэх мэт), эсхүл арилдаггүй бэхээр бичиж, тендерт оролцгчийг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж баталгаажуулна. Тендерт оролцгчийн боловсруулсан тендерийн агуулга, үнэтэй холбоотой бүх хуудсанд төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж цахимаар ирүүлнэ. Тайлан болон бусад байгууллагын гаргасан албан ёсны мэдээлэл зэрэг баримт бичиг үүнд хамаархгүй.

Г. ТЕНДЕР ИРҮҮЛЭХ

23. Тендерийг битүүмжлэх, бичиглэл хийх

23.1. Тендерт оролцогч өөрийн тендерийг хялбаршуулсан цахим хэлбэрээр [/www.tender.gov.mn/](http://www.tender.gov.mn/) сайтаар хүргүүлнэ.

23.2. Тендерт дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

- (а) тендерт оролцгчийн нэр, хаяг, холбоо барих утасны дугаартай байх;
- (б)
- (в) тендер шалгаруулалтыг таних, ялгах тэмдэг болгож ТОӨЗ-ны 1.1 болон **ТШӨХ-д** тодорхойлсон тендер шалгаруулалтын нэр/дугаарыг тодорхой бичсэн байх;

23.3. Хэрэв тендер буруу хаягаар хүргэгдсэн тохиолдолд захиалагч хариуцлага хүлээхгүй.

23.4. ТОӨЗ-ны 23.1-т зааснаас өөр хэлбэрээр ирүүлсэн аливаа тендерийг захиалагч хүлээж авахгүй бөгөөд түүнийг хаягаар нь буцаанаа.

24. Тендер хүлээн авах эцсийн хугацаа	24.1. Захиалагч тендерүүдийг www.tender.gov.mn сайтаар PDF файл болгон ирүүлнэ, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна. 24.2. Захиалагч ТОӨЗ-ны 9 дүгээр зүйлийн дагуу тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулсны улмаас тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгасан тохиолдолд захиалагч болон тендерт оролцгчийн эрх, үүрэг сунгасан хугацааны туршид хэвээр хадгалагдана.
25. Хугацаа хоцорсон тендер	25.1. Захиалагч ТОӨЗ-ны 24 дүгээр зүйлд заасан тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш ирүүлсэн аливаа тендерийг “хугацаа хоцорсон” гэж зарлан түүнээс татгалзаж, нээлгүйгээр буцаана.
26. Тендерт оролцогч нэгтгээд нэг тендер ирүүлэх	26.1. Аливаа этгээд дангаараа, эсхүл хамтран ажиллах гэрээний үндсэн дээр түншлэл болж тендер шалгаруулалтад оролцохдоо зөвхөн нэг тендер ирүүлнэ. Тендерт оролцогч болон түншлэлийн гишүүд нэгээс дээш тендер ирүүлсэн, бол түүний ирүүлсэн бүх тендерээс татгалзана.
27. Тендерт нэмэлт өөрчлөлт хийх, тендерийг буцааж авах	27.1. Тендерт оролцогч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагчид бичгээр мэдэгдэл өгсний үндсэн дээр өөрийн тендерт нэмэлт өөрчлөлт оруулах, солих, эсхүл түүнийг буцааж авах эрхтэй. 27.2. Тендерт нэмэлт өөрчлөлт оруулах, тендерийг солих эсвэл буцааж авах мэдэгдлийг 22, 23 дугаар зүйлийн дагуу бэлтгэн, битүүмжилж, бичиглэл хийхийн хамт доторх ба гаднах дугтуй дээр “НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ”, “ТЕНДЕРИЙГ СОЛИХ ТУХАЙ”, эсхүл “ТЕНДЕРИЙГ БУЦААЖ АВАХ ТУХАЙ” гэсэн бичиглэл хийнэ. Тендерийг буцааж авах мэдэгдлийг утсан холбоогоор ирүүлж болох ба энэ мэдэгдэл хүчин төгөлдөр болохыг батламжилж гарын үсэг, тамга бүхий эх хувийг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө заавал ирүүлнэ. 27.3. Тендер хүлээн авах эцсийн хугацаа өнгөрснөөс хойш аливаа тендерт ямар нэг нэмэлт өөрчлөлт хийх, солих, эсвэл буцааж авахыг зөвшөөрөхгүй. 27.4. ТОӨЗ-ны 27.2-т заасны дагуу тендерээ буцааж авах тухай хүсэлт ирүүлсэн оролцгчийн үндсэн тендерийг нээлгүйгээр буцаан олгоно. 27.5. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас тендер хүчинтэй байх хугацааны хооронд тендерийг буцааж авах нь 21 дүгээр зүйлийн дагуу тендерийн баталгааг улсын орлого болгох үндэслэл болно.

Д. ТЕНДЕРИЙГ НЭЭХ, ҮНЭЛЭХ

28. Тендерийг нээх	28.1. Захиалагч тендерийн нээлтийг ТШӨХ-д заасан огноо, цагт, заасан хаяг бүхий газарт зохион байгуулна. Тендер нээх үед тендерт оролцогч, эсхүл түүний төлөөлөгч болон сонирхсон бусад этгээд байлцах эрхтэй ба байлцсан бол тендерийн нээлтийн тэмдэглэл гарын үсгээ зурна. 28.2. Захиалагч эхлээд “ТЕНДЕРИЙГ БУЦААЖ АВАХ ТУХАЙ” гэсэн бичиглэл бүхий дугтуйг нээж, зарлах бөгөөд энэ хүсэлтийг ирүүлсэн оролцгчийн үндсэн тендерийг нээлгүйгээр буцаана. Дараа нь “ТЕНДЕРИЙГ СОЛИХ ТУХАЙ” бичиглэл бүхий тендерийг нээж зарлах бөгөөд уг тендерийг ирүүлсэн оролцгчийн урьд ирүүлсэн тендерийг нээлгүйгээр түүнд буцаан олгоно. “ТЕНДЕРТ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ” бичиглэл бүхий дугтуйг түүнд харгалзах үндсэн тендерийн хамт нээж нийтэд зарлана. 28.3. Тендерийг нээх үед тендерт оролцгчийн нэр, тендерийн үнэ, санал
---------------------------	--

болгосон бол үнийн хөнгөлөлт, хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд түүний үнэ, тендерийн баталгаа байгаа эсэх, оролцогч өөрийн тендерт нэмэлт өөрчлөлт оруулсан бол уг нэмэлт өөрчлөлтийг болон захиалагч шаардлагатай гэж үзсэн бусад мэдээллийг зарлаж, тэмдэглэл үйлдэнэ. Тендер нээх үед зарлагдаагүй тендерийн үнэ, үнийн хөнгөлөлт болон хувилбарт тендерийг үнэлгээнд харгалзахгүй.

28.4. Захиалагч тендерийн нээлтийн тэмдэглэлийг хөтлөх бөгөөд уг тэмдэглэл нь дараах мэдээллийг заавал агуулсан байна. Үүнд:

- (а) тендерт оролцогчийн нэр болон тухайн тендерт оролцогч тендерээ буцааж авсан, эсхүл тендерт нэмэлт өөрчлөлт оруулсан буюу тендерээ сольсон эсэх;
- (б) тендерийн үнэ болон санал болгосон үнийн хөнгөлөлт(зөвшөөрсөн бол хувилбарт тендерийн үнэ).Нэгээс дээш багцтай тендер шалгаруулалтын үед эдгээр мэдээллийг багц тус бүрээр гаргах;
- (в) захиалагч тендерийн баталгаа шаардсан бол түүнийг ирүүлсэн эсэх.

29. Нууцлах

- 29.1. Тендерийг хянан үзэх, тодруулах, үнэлэх, харьцуулах болон гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжтэй холбогдсон мэдээллийг гэрээ байгуулах эрх олгох хүртэлх хугацаанд тендерт оролцогчид болон тухайн тендер шалгаруулалтын үйл ажиллагаатай албан ёсоор холбогдолгүй аливаа этгээдэд задруулахыг хориглоно.
- 29.2. Захиалагч тендерийг хянан үзэх, үнэлэх, харьцуулах явцад, эсхүл гэрээ байгуулах эрх олгох шийдвэрт тендерт оролцогчоос нөлөөлөх гэсэн аливаа оролдлого нь тухайн оролцогчийн тендерээс татгалзах үндэслэл болно.
- 29.3. Тендерийн нээлт хийснээс хойш гэрээ байгуулах эрх олгох хүртэл хугацаанд захиалагч болон тендерт оролцогчид хоорондоозөвхөн бичгээр харилцана.

30. Тендерийг тодруулах

- 30.1. Тендерийг хянан үзэх, үнэлэх болон харьцуулах явцад тендерийг үнэлэхэд зайлшгүй шаардлагатай бол захиалагч тендерт оролцогчоос түүний тендерийн талаар тодруулга ирүүлэхийг хүсч болно. Тендерийг тодруулахтай холбоотой аливаа харилцааг бичгээр явуулна.Гэхдээ 31 дүгээр зүйлийн дагуу тендерийг хянан үзсэний үндсэн дээр захиалагчийн илрүүлсэн арифметик алдааг залруулахаас бусад тохиолдолд тендерийн үнэ болон агуулгад ямар нэг өөрчлөлт хийхийг хүсэх, санал болгохыг зөвшөөрөхгүй.

31. Тендерийг хянан үзэх, шаардлагад нийцсэн эсэхийг тогтоох

- 31.1. Аливаа тендерийг нарийвчлан үнэлэхээс өмнө уг тендер нь дараахь шаардлагыг хангаж буй эсэхийг хянан үзнэ. Үүнд:
 - (а) ТОӨЗ-ны 4 дүгээр зүйлд заасан эрх бүхий тендерт оролцогч байх шаардлагыг хангасан эсэх;
 - (б) тендерт зохих ёсоор гарын үсэг зурж, баталгаажуулсан эсэх;
 - (в) зөвшөөрөгдсөн маягтын дагуу захиалагчийн шаардлагыг хангасан тендерийн баталгаа ирүүлсэн эсэх;
 - (г) тендерийн баримт бичигт тавигдсан бусад шаардлагад нийцсэн эсэх;
 - (д) тендерт оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадварын доод шаардлагыг хангасан эсэх.

- 31.2. ТОӨЗ-ны 31.1 дэх заалтын (а) - (д)-д заасан заалт тус бүрийг хангаж буй тохиолдолд шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ.
- 31.3. Шаардлагад нийцсэн тендер гэж тендерийн баримт бичгийн бүх нөхцөл болзول, тендерт оролцгчийн үйлдвэрлэлийн хүчин чадал, санал болгосон бараа нь ТОӨЗ-ны 19 дүгээр зүйлд заасан нөхцөл болон техникийн тодорхойлолтыг материаллаг зөрүүгүйгээр хангаж буй тендерийг хэлнэ. Дор дурдсан зүйлсийг материаллаг зөрүү гэж үзнэ. Үүнд:
- (а) тендерт санал болгож буй бараа нь техникийн тодорхойлолт болон гэрээний нөхцөлд тодорхойлсон барааны хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхээр бол;
 - (б) гэрээнд заасан захиалагчийн эрх, тендерт оролцгчийн үүрэгт тендерийн баримт бичигтэй үл нийцэх зарчмын хязгаарлалт оруулсан бол;
 - (в) зөрүүг хүлээн зөвшөөрч засварлах буюу залруулах нь шаардлагад нийцсэн бусад тендерийн өрсөлдөөнд шударга бусаар нөлөөлөх бол.
- 31.4. Захиалагч шаардлагад үл нийцсэн гэж тогтоогдсон тендерээс татгалзана. Харин тендерт оролцогч түүнд засвар хийж шаардлагад нийцсэн болгож болохгүй.
- 32. Алдааг залруулах**
- 32.1. Захиалагч шаардлагад нийцсэн гэж тодорхойлогдсон тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна. Үүнд:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзэж тоондунг засварлах;
 - (б) нэр төрлийн нийт үнийн нийлбэр нь тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл нэр төрлийн нийт үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулах; Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
 - (в) нэр төрлийн нийт үнэ нь түүний нэгж үнийг тоо ширхэгээр үржүүлэхэд гарсан үнээс зөрвөл нэр төрлийн нэгж үнийг үндэслэн түүний нийт үнийг залруулна. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 32.2. Захиалагч, “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн үнэндзалруулга хийхээр байвал энэ талаар тухайн тендерт оролцогчид мэдэгдэж, хүлээн зөвшөөрсөн эсэхийг бичгээр баталгаажуулж авна.
- 33. Нэг валютад хөрвүүлэх**
- 33.1. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасны дагуу Монгол банкнаас албан ёсоор зөвшөөрсөн тохиолдолг ТОӨЗ-ны 16 дугаар зүйлд зааснаас өөр валютаар тендерийн үнийг илэрхийлж болно. Ийм тохиолдолд захиалагч тендерийн үнэлгээ, харьцуулалтыг хийхдээ тендерийн үнийг тендер зарласан өдрийн Монголбанкны ханшаар төгрөгт хөрвүүлнэ.
- 34. Дотоодын давуу эрх**
- 34.1. Захиалагч ТШӨХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд тендерүүдийг үнэлж харьцуулахдаа Монгол Улсын гарал үүсэлтэй бараа санал болгосон тендерт бусад гарал үүсэлтэй бараа санал болгосон тендертэй харьцуулахад давуу эрхийн зөрүү олгохгүй.
- 35. Тендерийг үнэлэх, харьцуулах**
- 35.1. Захиалагч зөвхөн 31 дүгээр зүйлийн дагуу шаардлагад нийцсэн гэж тогтоогдсон тендерийг үнэлж, харьцуулна.

35.2. Захиалагч тендерийг үнэлэхдээ дараах байдлаар тендерийн үнэд залруулга хийж, тендерийн харьцуулах үнийг тодорхойлно. Үүнд:

- (а) ТОӨЗ-ны 32 дугаар зүйлийн дагуу арифметик алдааг тооцож тендерийн үнийг залруулах;
- (б) ТОӨЗ-ны 31.3дугаарзүйлийн дагуу томоохон зөрүү гэж тооцоогүй бага хэмжээний орхигдуулсан зүйл буюу тоо хэмжээний зөрүүг тооцон мөнгөөр илэрхийлж, тендерийн үнэд залруулга хийх;
- (в) тендерт оролцогчийн санал болгосон нэмэлт өөрчлөлт буюу үнийн хөнгөлөлтийг тусгах;
- (г) захиалагч энэ тендерийн баримт бичгийн 3 дугаар бүлэг буюу үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг түүнд холбогдох аргачлалын дагуу тооцон мөнгөөр илэрхийлж, түүнийг тендерийн үнэд нэмж тооцох;
- (д) ТШӨХ-д зөвшөөрсөн бол дотоодын давуу эрхийн зөрүүг холбогдох аргачлалын дагуу тооцох.

35.3. Шаардлагад нийцсэн тендерүүдийг 35.2-т заасны дагуу үнэлгээ хийжтэндер тус бүрийн харьцуулах үнийг тогтооно. Хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер гэж шалгаруулна.

35.4. ТШӨХ-д заасны дагуу хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд “хамгийн сайн” үнэлэгдсэн үндсэн тендерийн хувилбарт тендер үндсэн тендерээс илүү нөхцөл хангасан бол хувилбарт тендерийг шалгаруулна.

35.5. Барааг ТОӨЗ-ны 1.2 дахь хэсэгт хоёр буюу түүнээс дээш багцад хуваасан бол захиалагч үнэлгээг багц тус бүрт хийх бөгөөд харин гэрээ байгуулах эрх олгоходо нэг багц, хэд хэдэн багц, эсхүл бүх багцын аль үр ашигтай хувилбарыг сонгож болно.

35.6. Олон багцтай тендер шалгаруулалтад “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийг шалгаруулж, тэдгээрт гэрээ байгуулах эрх олгох хамгийн үр ашигтай хувилбарыг сонгохдоозахиалагч 3 дугаар бүлэг буюу үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт дэхь олон багцтай тендерийг үнэлэх тухай тусгайлан заасан аргачлалыг мөрдөнө.

36. Тендерт оролцогчийн чадварыг дахин магадлах

36.1. Захиалагч шаардлагад нийцсэн, хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадвартай эсэхийг дахин магадлаж болно.

36.2. Тендерт оролцогчийн чадварыг тодорхойлоходо ТОӨЗ-ны 18.1-д заасны дагуу тендерт оролцогчийн ирүүлсэн чадварыг нотлох баримт болон ТОӨЗ-ны 30 дугаар зүйлийн дагуу хийсэн шаардлагатай нэмэлт тодруулгад үндэслэн ТОӨЗ-ны 18.2-т заасан чадварын шаардлагыг хангасан эсэхийг тодорхойлно. Захиалагч 18.2 болон тендерийн үнэлгээнд харгалзах чадварын шалгуур үзүүлэлтэд заагаагүй бусад шалгуур үзүүлэлтийг тендерийг хянан үзэх, тендерт оролцогчийн чадварыг тогтооход ашиглахгүй.

36.3. “Хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг дахин магадлаад, шаардлага хангасан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгоно. Хэрэв шаардлага хангахгүй бол уг тендерээс татгалzan сайн гэж үнэлэгдсэн дараагийн тендерт оролцогчийн чадварыг мөн адил зарчмаар магадлана.

37. Аливаа

37.1. Захиалагч тендер шалгаруулалтыг үндэслэлгүйгээр хүчингүй болгохыг

**тендерийг
сонгох, эсхүл
тендерүүдээс
татгалзах
захиалагчийн
эрх**

хориглоно.

E. ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЭРХ ОЛГОХ

- 38. Гэрээ байгуулах
эрх олгох
шалгуур**
- 38.1. Захиалагч шаардлагад нийцсэн бөгөөд 35.3-т заасны дагуу “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн тендер ирүүлсэн тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгоно.
- 38.2. “Хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч ТОӨЗ-ны 32 дугаар зүйлийн дагуу захиалагчийн залруулсан арифметик алдааг хүлээн зөвшөөрөгүй бол гэрээ байгуулахаас татгалзсан гэж тооцож, тендерээс татгалзах бөгөөд 21.9(б)-д заасны дагуу тендерийн баталгааг улсын орлого болгоно.
- 39. Гэрээ байгуулах
эрх олгох
мэдэгдэл**
- 39.1. Захиалагч нь гэрээ байгуулах эрх олгох шийдвэрээ гаргаж тендер нь шалгарсан оролцогч болон бусад тендерт оролцогчид нэгэн зэрэг бичгээр хүргүүлнэ.
- 39.2. Шалгарсан тухаймэдэгдэлд гэрээнд заасны дагуу нийлүүлэгдэх бараанд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлт үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.
- 39.3. Захиалагч Засгийн газрын худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим хуудсанд тендерийн нэр болон багцын дугаарыг дараахь мэдээллийн хамтаар гэрээ байгуулах эрх олгосон даруй нийтэлнэ. Үүнд:
- 1) тендер ирүүлсэн оролцогч бүрийн нэр;
 - 2) тендерийн нээлтэнд зарлагдсан үнийн саналууд;
 - 3) нарийвчлан үнэлэгдсэн тендерийн нэр, үнийн санал;
 - 4) тендерээс нь татгалзсан оролцогчийн нэр, татгалзсан шалтгаан;
 - 5) тендер нь шалгарсан оролцогчийн нэр, түүний санал болгосон тендерийн үнэ, гэрээний үнийн дүн.
- 39.4. Гэрээ байгуулахээрх олгосон шийдвэрийг мэдээлсний дараа шалгараагүй тендерт оролцогч өөрийн тендерийнүүнэлгээний талаар тайлбар авах хүсэлтийг бичгээр гаргаж болно. Хүсэлт гаргасан тохиолдолд захиалагч бичгээр хариу өгнө.
- 39.5. Тендер нь шалгарсан оролцогч ТОӨЗ-ны 42 дугаар зүйлийн дагуу гаргасан гүйцэтгэлийн баталгаа гаргаж, гэрээний маягтанд гарын үсэг зурж ирүүлсэн даруй захиалагч ТОӨЗ-ны 21.8-д заасны дагуу тендерийн баталгааг хүчингүй болгож, энэ тухайг шалгараагүй бусад тендерт оролцогчид мэдэгдэнэ.
- 40. Захиалагч гэрээ
байгуулах эрх
олгох үед тоо
хэмжээг
өөрчлөх**
- 40.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаас бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх төслөл арга хэмжээний үед захиалагч гэрээ байгуулах эрх олгох үед үнэ, бусад нөхцөл болзлыг үл өөрчлөн техникийн тодорхойлолтод дурдсан барааны тоо ширхэгийг ТШӨХ-д заасан хувиар өөрчлөх эрхтэй.
- 41. Гэрээнд гарын**
- 41.1. Захиалагч гэрээний маягт болон талуудын хооронд тохирсон бүх

үсэг зурах

нөхцөлийг тусгасан тохиролцоог гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийн хамт шалгарсан тендерт оролцогчид илгээнэ.

42. Гүйцэтгэлийн баталгаа

- 41.2. Шалгарсан тендерт оролцогч гэрээний маягтыг хүлээн авснаас хойш ажлын 5-аас дээш хоногийн дараа ТШӨХ-д тусгайлан заасан хугацаанд багтаантүүнд гарын үсэг зурж захиалагчид хүргүүлнэ.
 - 41.3. Захиалагч шалгарсан тендерт оролцогчийг гүйцэтгэлийн баталгаа ирүүлсний дараа ТОӨЗ-ны 39.4-т нийцүүлэн гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулна.
 - 42.1. Гүйцэтгэлийн баталгааг гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэлд заасан хугацаанд багтаан, ТШӨХ, гэрээний тусгай нөхцөлд тусгайлан заасан хэлбэр, дүнгээр ирүүлнэ.
 - 42.2. Шалгарсан тендерт оролцогч ТШӨХ-д тусгайлан заагаагүй тохиолдолд гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхгүй байж болно.
 - 42.3. Шалгарсан тендерт оролцогч ТОӨЗ-ны 42.1-д заасан шаардлагыг биелүүлээгүй нь гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгох болон тендерийн баталгааг гүйцэтгүүлэх үндэслэл болно.
-

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

Худалдан авах барааны талаарх дор дурдсан өгөгдлүүд нь тендерт оролцогчид өгөх зааварчилгаа/ТОӨЗ/-ны холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. Хэрэв ТОӨЗ-ны зүйл, заалттай зөрчилдвэл энэхүү хүснэгт дэх мэдээллийг зөв гэж үзнэ.

ТОӨЗ-ны холбогдох заалт	A. Ерөнхий зүйл
ТОӨЗ 1.1	Захиалагч нь: “ <i>Монгол Шуудан</i> ” ХК
ТОӨЗ 1.2	Хязгаарлагдмал тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар: “ <i>Шатахуун нийлүүлэх</i> ”, МШ/201901130
ТОӨЗ 1.3	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <i>Багцгүй</i>
ТОӨЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: <i>Компанийн өөрийн эх үүсвэр</i>
	B. Тендерийн баримт бичиг
ТОӨЗ 8.1	Захиалагчаас тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга авах хаяг: <i>Монгол Шуудан ХК, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,</i> <i>Энхтайвны өргөн чөлөө , 1-р хороо,</i> <i>Монгол Шуудангийн төв байр 2 давхарт 203 тоот,</i> <i>Утас/Факс: 70078977/</i>
ТОӨЗ 8.1	Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг хүлээн авах хугацааны хязгаар тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын 5 хоногоос багагүй байна.
	C. Тендер бэлтгэх
ТОӨЗ 11.1	Тендерийн хэл нь: <i>Монгол.</i> <i>Гэрээ хийгдэх хэл нь Монгол байна.</i>
ТОӨЗ 12.1	12.1 (а) - (ё)-д заасан баримт бичгээс гадна дараах материалыг нэмж бүрдүүлнэ: <i>1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, шүүхийн тодорхойлолтууд, тендерт оролцогчийн харьяа газрын нийгмийн даатгал, татварын алба болон харилцагч банкны байгууллагын тодорхойлолт</i> <i>2. Нийлүүлэх АИ-92, А-80, Дизель түли, Автогазны танилцуулгыг</i>

	<p>хавсаргаж ирүүлэх</p> <p>3. Татварын өргүй байх бөгөөд татвар, нийгмийн даатгалын байгууллагаас захиалагч тодорхойлолт, лавлагaa авахад татгалзах зүйлгүй тухай албан бичиг хавсарган ирүүлэх</p> <p>4. Тусгай зөвшөөрөл хавсарган ирүүлэх</p>
ТОӨЗ 14.1	Хувилбарт тендер ирүүлэхийг “зөвшөөрөхгүй”
ТОӨЗ 15.5	Олон улсын худалдааны Incoterms/Инкотермс-ийн хувилбар: “ <i>Incoterms 2010DDP</i> ”
ТОӨЗ 15.8 (6) (1) болон (в) (3)	Бараа хүргэгдэх газар: <i>Улаанбаатар хот, 21 аймгийн төв /аймгийн төв цэгээс 2 километрийн радиус дотор салбартай байх/, бүх сумуудад өөрийн шатахуун түгээх станцаар олгох</i>
ТОӨЗ 15.9 (а) (3);(б)(3) болон (в)(5)	Бараа хүргэгдэх эцсийн цэгт барааг хүргэх хүртэл нийлүүлэгч өөрийн агуулахад хадгалж, хүргэнэ. <i>Улаанбаатар хот, 21 аймгийн төв /аймгийн төв цэгээс 2 километрийн радиус дотор салбартай байх/, бүх сумуудад салбартай байх</i>
ТОӨЗ 15.10	Төлбөрийн систем нь бүх салбуруудад шатахууны карт, талоноор шатахуун олгодог байх.
ТОӨЗ 15.11	Байгууллага нь дурын интернет хөтөч болон гар утасны апликејши ашиглан шатахууны худалдан авалтын мэдээллийг цаг тухай бүрт нь хурдан шуурхай хүлээн авдаг байх.
ТОӨЗ 15.12 (6) (1)	Монгол Улсын хилээс гадна үйлдвэрлэгдэх барааг нийлүүлэх үнэ нь ТОӨЗ-ны 15.9.(б).(1) дэх хэсэгт заасан үнээр санал болгоно.
ТОӨЗ 15.13	Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад “ <i>тохируулахгүй тогтолцоул баина.</i> ” <i>Үнийн саналд НӨАТ, холбогдох бүх татвар, хураамж, тээврийн зардал, нэмэлт бүх зарлуудыг тооцож ирүүлнэ..</i>
ТОӨЗ 16.1	Тендерийн валют: <i>Төгрөг баина.</i>
ТОӨЗ 18.1 (а)	Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл: <i>Үйлдвэрлэгчийн эсвэл дистербьютерийн зөвшөөрөл шаардлагатай.</i>
ТОӨЗ 18.1 (б)	Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: <i>2 жил (2017 он, 2018 оны аудитаар баталгаажсан санхүүгийн тайланг нотариатаар батлуулан ирүүлнэ).</i>
ТОӨЗ 18.1 (г)	Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: <i>Сүүлийн 2 жил (2017 он, 2018 он).</i> Хийгдсэн ажлын жагсаалтыг хавсаргана. Сүүлийн нэг жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: <i>1 буюу</i>

	<i>түүнээс дээши удаа санал болгож буй үнийн дунгийн 50 хувиас багагүй хэмжээний ажлыг хэрэгжүүлсэн байх. Ижил төстэй ажилд зөвхөн гэрээ, актыг нотариатаар батлуулан ирүүлнэ. Гэрээ, актыг нотариатаар батлуулан ирүүлнэ</i>
ТОӨЗ 18.1 (д)	Барааг нийлүүлсний дараах засвар, үйлчилгээ:
ТОӨЗ 18.2 (а)	Борлуулалтын хэмжээ: <i>Сүүлийн 2 жилийн борлуулалтын дундаж дун нь санал болгож буй үнийн дунгээс багагүй байх (2017 он, 2018 он)</i>
ТОӨЗ 18.2 (б)	Гүйцэтгэгчээр ажилласан байх жилийн тоо: <i>1 жил (2018 он)</i>
ТОӨЗ 18.2 (в)	Гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмжийн жагсаалт:
ТОӨЗ 18.2 (г)	Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: : <i>Санал болгож буй үнийн дунгээс багагүй.</i>
ТОӨЗ 18.2 (д)	Ашигтай ажилласан байх жилийн тоо: <i>Хоёр жил /2017 он, 2018 он/</i>
ТОӨЗ 18.3	Дотоодын давуу эрхийн зөрүү “ <i>тооцно</i> ”
ТОӨЗ 19.1.(б)	Барааг тасралтгүй горимын дагуу ашиглах, эсхүл ажиллуулахаар тооцоолж буй хугацааны үе (энэ хугацаанд шаардагдах сэлбэг хэрэгслийг тооцоолох зорилготой):
ТОӨЗ 20.1	Тендер нээснээс хойш 30 хоногийн туршид хүчинтэй байна.
ТОӨЗ 21.1	Тендерийн баталгааны үнийн дүн: 10,000,000 /Арван сая/ төгрөг. Хүчинтэй байх баталгааны хугацаа: 2019 оны 08 дугаар сарын 09-ний өдрийг дуустал.
ТОӨЗ 22.1	Тендерийн эх хувиас гадна ирүүлэх хуулбар хувийн тоо: Шаардлагагүй Г. Тендер ирүүлэх
ТОӨЗ 23.3 (б)	Тендер хүлээн авах захиалагчийн хаяг: “Хялбаршуулсан цахим” www.tender.gov.mn
ТОӨЗ 23.3 (в)	Хязгаарлагдмал тендер шалгаруулалтыг хялбаршуулсан: “Шатахуун нийлүүлэх” гүйцэтгэгчийг сонгон шагларуулах, МШ/201901130
ТОӨЗ 24.1	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдөр. Цаг: 10 цаг 00 минут Д. Тендерийг нээх, үнэлэх
ТОӨЗ 28.1	Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд: Тендер хүлээн авах захиалагчийн хаяг: Чингэлтэй дүүрэг, Энхтайвны

	<p>өргөн чөлөө, 1 хороо, Монгол Шуудан ХК-ны төв байр Давхар болон өрөөний дугаар: 2-р давхар, 203 тоот Аймаг, хот: Улаанбаатар хот Шуудангийн дугаар: Улс: “Монгол Улс” Тендерийн нээлт хийх огноо, цаг нь: Огноо: 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдөр. Цаг: 10 цаг 15 минут</p>
	Е. Гэрээ байгуулах эрх олгох
ТОӨЗ 40.1	Захиалагч барааны тоо хэмжээг бууруулж болох хамгийн их хувь: 10% Нийлүүлэх барааны тоо хэмжээг өсгөж болох хамгийн их хувь: 10%

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Энэ хэсэг нь ТОӨЗ-ны хэсэг бөгөөд захиалагч ТШӨХ-д тусгайлан зөвшөөрсөн бол тендерийн үнэлгээг хийхдээ тендерийн маягтанд тусгасан үнийн саналаас гадна ТОӨЗ-ын 35.2 (г)-д заасан нэг буюу хэд хэдэн хүчин зүйлийг харгалзан үзэж болох бөгөөд ингэхдээ дараах шалгуур болон аргачлалыг ашиглан мөнгөөр илэрхийлж, тендерийн маягтад дурдсан үнэд харгалзан тооцсоны үндсэн дээр тендерийн харьцуулах үнийг гаргана. Захиалагч энэ хэсэгт зааснаас өөр бусад аливаа шалгуур үзүүлэлт, аргачлалыг үнэлгээнд харгалзахгүй.

- (a) Гэрээний болон арилжааны зөрүү “**Ашиглахгүй**”
- (a) Бараа нийлүүлэлтийн хуваарь:
- (b) Төлбөрийн хуваарийн зөрүү: “**ашиглахгүй**”
- (b) Тендерийн дагуу санал болгож байгаа бараа (тоног төхөөрөмж)-ны гол эд анги, зайлшигүй шаардлагатай сэлбэг хэрэгсэл болон үйлчилгээний зардал: “**ашиглахгүй**”
- (g) Тендертсанал болгосон бараа (тоног төхөөрөмж)-ны борлуулалтын дараах үйлчилгээг захиалагчийн байгаа улсад үзүүлэх боломж “**ашиглахгүй**”
- (d) Тендерийн дагуу санал болгосон бараа (тоног төхөөрөмж)-ны ашиглалтын болон хэвийн ажиллагааг хангахад шаардагдах зардал: “**ашиглахгүй**”
- (e) Тендерт санал болгосон бараа (тоног төхөөрөмж)-ны үр ашиг болон үйл ажиллагааны баталгаа: “**ашиглахгүй**”

(ë) Барааны дотоодын тээвэрлэлт, даатгал болон бусад зардал: “*ашиглахгүй*”

Олон багцтай тендерийг үнэлэх

ТОӨЗ-ны 35.6-д заасны дагуу захиалагч нэг ба түүнээс дээш багцаар гэрээ байгуулах эрхтэй бол олон багцыг үнэлж гэрээ байгуулах эрх олгоход дараах аргачлалыг мөрдөнө.

Захиалагч багцуудын хамгийн сайн үнэлэгдсэн буюу хамгийн үр ашигтай байх хувилбарыгдараах байдлаар сонгоно. Үүнд:

- (a) ТОӨЗ-ны 15.8-д зааснаар багц тус бүрт байх барааны нэр төрөл болон нэр төрөл тус бүрийн тоо хэмжээ нь бүрэн бол тухайн багцад үнэлгээ хийнэ.
- (б) Үнэлгээнд дараах журмыг баримтална:
- (i) багц тус бүрт үнэлгээний шалгуурыг хангасан хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг тогтоох;
 - (ii) тендерт оролцгчийн тухайн хамгийн сайн үнэлэгдсэн тендерт санал болгосон үнийн хөнгөлөлтийг санал болгосон аргачлалын дагуу багц тус бүрт тооцох;
 - (iii) эдийн засгийн хувьд хамгийн үр ашигтай байххувилбараар гэрээ байгуулах эрх олгохоор сонгох. Ингэхдээ нэг тендерт оролцогч 2 ба түүнээс дээш багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн бол түүний гэрээг хэрэгжүүлэх чадварыг дахин магадлаж тогтооно. Хэрвээ тухайн оролцогч 2-оос дээш багцад гэрээ хэрэгжүүлэх чадвар нь хангалтгүй гэж үнэлэгдвэл түүний чадавхид тохирох багцад гэрээ байгуулах эрх олгож болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

МАЯГТ №: ТШМ-1

ТЕНДЕРИЙН МАЯГТ

[огноо]

Монгол шуудан ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Анхбаатар танаа

- Бид, *[тендерт оролцогчийн нэрийг оруул]*, энэхүү тендерийн баримт бичгийн шаардлагад нийцсэн *[бараа болон бусад үйлчилгээний нэрийг оруул]-г [тендерийн унийг тоогоор болон үсгээр оруул]* төгрөгөөр тендерийн баримт бичигт заасан бараа нийлүүлэлтийн хуваарийн дагуу нийлүүлэхээр санал болгож байна.
- Бидний тендер шалгарсан тохиолдолд гэрээнд заасан барааг гэрээ байгуулнаас хойш *[моо]* хоногийн дотор нийлүүлнэ. Энэ нь техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарьт үндэслэнэ.
- Бидний санал болгож байгаа тендер шалгарсан тохиолдолд дараах үнийн хөнгөлөлт *[үзүүлиэхгүй гэдгийн аль нэгийг оруулах]* *[Үнийн хөнгөлөлт үзүүлэхээр бол техникийн тодорхойлолтонд дурдсан бараа болон бусад үйлчилгээний аль хэсэг, нэр төрөлд эсхүл бүхэлд нь ямар хөнгөлөлт үзүүлэх саналтай байгаа, үнийн хөнгөлөлт тооцох аргачлалыг хэрхэн хэрэглэх талаарх саналаа оруул]* үзүүлнэ.
- Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээснээс **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- Бид, энэхүү тендер шалгаруулалтаар нийлүүлэгдэх бараа, түүнийг дагалдах бусад үйлчилгээний техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээд болон үнэлгээний хорооны гишүүдтэй нэгдмэл сонирхолгүй болохоо мэдэгдэж байна.
- Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

**МОНГОЛ УЛСАД ҮЙЛДВЭРЛЭГДСЭН
БАРААНЫ ҮНИЙН ХУВААРЬ**

Огноо: _____

(А ангилал)

НТШ-ын дугаар: _____

Тендерийн урилгын дугаар: _____

Хувилбарт тендерийн дугаар: _____

Хуудасны ____ -ын ____ дугаар ____

ТОӨЗ-НЫ 16-Д ЗААСАН ВАЛЮТААР

1	2	3	4	5	6	7	8	9	10
Нэр төрөл	Барааны тодорхойлолт	Гарал үүслийн улс	Тоо ширхэг болон эд анги	EXW нэгж үнэ	Нэр төрөл бүрийн EXWбүгд үнэ (4x5)	Барааг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээний үнэ (хэрэв ТШХ, ТОӨЗ-НЫ 15.9.(а).(3)-д шаардсан бол)	Монгол улсын нутаг дэвсгэр дээр бий болсон буюу дотоодын ажиллах хүч, түүхий эд болон бусад үйлчилгээний өртөгийн 6-р баганад заасан үнэд эзлэххувь	ТОӨЗ-НЫ 15.9.(а).(2)-д заасан гэрээ байгуулах эрх олгосон тохиолдолд төлөх НӨТ болон бусад татвар хураамж	Нэр төрөл бүрийн нийт үнэ (6+7+9)
Тендерийн нийт үнэ (10)									

Тендерт оролцогчийн нэр _____ Гарын үсэг _____ Огноо _____

МАЯГТ №: ТШМ -2Б

**МОНГОЛ УЛСЫН ГАДНА ҮЙЛДВЭРЛЭГДСЭН БӨГӨӨД ИМПОРТООР ОРЖ ИРЭХ
БАРААНЫ ҮНИЙН ХУВААРЬ**

Огноо: _____

НТШ-ын дугаар: _____

Тендерийн урилгын дугаар: _____

(Б ангилал)

Хувилбарт тендерийн дугаар: _____

Хуудасны _____ -ын _____

ТОӨЗ-НЫ 16-Д ЗААСАН ВАЛЮТААР

1	2	3	4	5	6	7	8	9
Нэр төрөл №	Барааны тодорхой лолт	Гарал үүслийн улс	Тоо ширхэг	ТОӨЗ-НЫ 15.9 (б) (1)-Д ЗААСАН СИФ ЭСХҮЛ СИП НЭГЖ ҮНЭ	Нэр төрөл бүрийн СИФ эсхүл СИП нийт үнэ (4 x 5)	Барааг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээний үнэ (хэрэв ТШХ, ТОӨЗ-НЫ 15.9(б).(3)-Д шаардсан бол)	ТОӨЗ-НЫ 15.9(б).(2)-Д ЗААСНААР ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЭРХ ОЛГОСОН ТОХИОЛДОЛД ТӨЛӨХ НӨТ БОЛОН БУСАД ТАТВАР ХУРААМЖ	Нэр төрлийн нийт дүн (6 + 7+8)
Тендерийн нийт дүн (9)								

Тендерт оролцогчийн нэр _____ Гарын үсэг _____ Огноо _____

МАЯГТ №: ТШМ -2В

МОНГОЛ УЛСЫН ГАДНА ҮЙЛДВЭРЛЭГДСЭН БӨГӨӨД ИМПОРТООР ОРУУЛЖ ИРСЭН
БАРААНЫ ҮНИЙН ХУВААРЬ

Огноо: _____

НТШ-ын дугаар: _____

Тендерийн урилгын дугаар: _____

Хувилбарт тендерийн дугаар: _____

(В ангилал)

Хуудасны _____ -ын _____

ТОӨЗ-ны 16-д заасан валютаар

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Нэр төрөл №	Барааны тодорхойлолт	Гарал үүслийн улс	Инкотермд тусгасны дагуу хүргэх огноо	Тоо ширхэг	ТОӨЗ-ны 15.9 (в) (1)-д заасан урьд нь төлсөн болон төлөх гаалийн татвар хураамж болон импортын татварыг оруулсан нэгж үнэ	ТОӨЗ-ны 15.9(в). (2)-д заасан нэр төрөл бүрт төлсэн гаалийн болон импортын татвар хураамж [нотлох бичиг баримтыг үндэслэнэ]	ТОӨЗ-ны 15.9 (в) (3)-д заасны дагуу нэгж үнэ (гаалийн татвар хураамж болон импортын татварыг хассан нэр төрөл бүрийн үнэ (6 – 7))	ТОӨЗ-ны 15.9 (в) (3) (9=8x5)-д заасны дагуу гаалийн болон импортын татварыг хассан нэр төрөл бүрийн үнэ (6 – 7)	Барааг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээний үнэ (ТОӨЗ-ны 15.9(в) (5)-д шаардсан бол)	Гэрээ байгуулах эрх олгосон тохиолдолд төлөх НӨТ болон бусад татвар хураамж	Нэр төрөл бүрийн нийт үнэ (9+10+11)
Тендерийн нийт үнэ (12)											

Тендерт оролцогчийн нэр _____ Гарын үсэг _____ Огноо _____

3. ТЕНДЕРИЙН БАТАЛГААНЫ МАЯГТ (БАНКНЫ БАТАЛГАА)

Монгол шуудан ХК-д

[Тендерт оролцогчийн нэр] (цаашид “Тендерт оролцогч” гэх) нь [Тендер шалгаруулалтын нэр] бараа нийлүүлэхээр тендер (цаашид “Тендер” гэх) санал болгосонтой ХОЛБОГДУУЛАН,

Энэхүү баталгаагаар [Банкны нэр] (цаашид “Банк” гэх) нь [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх)-ийн өмнө нийт [мөнгөн дүн]-ийн төлбөр хийх үүрэг хүлээж батлан даалт гаргаж байна.

Төлбөр хийх үүрэг нь дор дурдсан нөхцөлд үүснэ. Үүнд:

- (1) тендерийг нээсний дараа тендерийн маягтад заасан тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө тендерт оролцогч өөрийн тендерийг буцааж авсан;
- (2) захиалагч тендер хүчинтэй байх хугацаанд багтаж гэрээ байгуулах эрх олгосон үед тендерт оролцогч:
 - (a) тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу гэрээг байгуулаагүй бол;
 - (b) тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй бол;
 - (в) тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу хийгдсэн тендерийн үнийн алдааны залруулгыг хүлээн зөвшөөрөөгүй бол.

Энд тодорхойлогдсон нөхцөлүүдийн аль нэг нь үүссэнийг дурдаж дээр зааснаас хэтрэхгүй мөнгөн дүнтэй тэнцэх төлбөр хийх тухай захиалагчийн анхны шаардлагыг бичгээр хүлээн авсан даруй төлбөрийг үл маргалдах журмаар хийнэ.

Энэхүү баталгаа нь **20..... он ...-р сар-ны өдрийг дуустал** хүчинтэй. Захиалагч баталгаатай холбогдсон аливаа шаардлагыг энэ хугацаанд багтаж банкинд мэдэгдэх ёстай.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Банкны эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Албан тушаал, нэр:

Банкны тамга:

Огноо:

Хаяг:

ТЕНДЕРИЙН БАТАЛГААНЫ МАЯГТ
(ЗАСГИЙН ГАЗРЫН БОНДЫН БАТАЛГАА)

Монгол шуудан ХК-д

[Тендерт оролцогчийн нэр] (цаашид “Тендерт оролцогч” гэх) нь [Тендер шалгаруулалтын нэр] бараа нийлүүлэхээр тендер (цаашид “Тендер” гэх) санал болгосонтой ХОЛБОГДУУЛАН,

Энэхүү баталгаагаар [Хөрөнгийн бирж] (цаашид “Бирж” гэх) нь [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх)-ийн өмнө нийт [мөнгөн дүн]-ийн төлбөр хийх үүрэг хүлээж тендерт оролцогчийн засгийн газрын бондыг¹ үндэслэн батлан даалт гаргаж байна.

Төлбөр хийх үүрэг нь дор дурдсан нөхцөлд үүснэ. Үүнд:

- (2) тендерийг нээсний дараа тендерийн маягтад заасан тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө тендерт оролцогч өөрийн тендерийг буцааж авсан;
- (3) захиалагч тендер хүчинтэй байх хугацаанд багтаж гэрээ байгуулах эрх олгосон үед тендерт оролцогч:
 - (а) тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу гэрээг байгуулаагүй бол;
 - (б) тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй бол;
 - (в) тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу хийгдсэн тендерийн үнийн алдааны залруулгыг хүлээн зөвшөөрөгүй бол.

Энд тодорхойлогдсон нөхцөлүүдийн аль нэг нь үүссэнийг дурдаж дээр зааснаас хэтрэхгүй мөнгөн дүнтэй тэнцэх төлбөр хийх тухай захиалагчийн анхны шаардлагыг бичгээр хүлээн авсан даруй засгийн газрын бондыг үл маргалдах журмаар шилжүүлнэ.

Энэхүү баталгаа нь *201.... он ...-р сар-ний өдрийг дуустал* өдрийг хүртэл хүчинтэй. Захиалагч баталгаатай холбогдсон аливаа шаардлагыг энэ хугацаанд багтаж биржид мэдэгдэх ёстай.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Банк /Биржийн эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Албан тушаал, нэр:

Биржийн тамга

Огноо:

Хаяг:

¹Засгийн газрын бондын эргэн төлөгдөх хугацаа нь тендер нээх өдрөөс хойш 3-аас доошгүй сарын дараа байна.

Үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн итгэмжлэл

[Тендерт оролцогч энд заасан зааврын дагуу үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчаар энэ маягтыг бөглүүлсэн байна. Энэхүү итгэмжлэлийг үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн албан бланкан дээр бичиж, түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурсан байна. ТШӨХ-д шаардсан тохиолдолд тендерт оролцогч үүнийг тендерийн хамт ирүүлнэ.]

Огноо: [тендер ирүүлсэн (өдөр, сар, он)]

НТШ-ын дугаар: [оруул:тендер шалгаруулалтын дугаар]

Хувилбарын дугаар: [оруул:энэнь хувилбарын дугаар]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

Бид, [оруул: үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн бүтэн хаяг]-д байршилтай [оруул: үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн бүрэн нэр] нь [оруул: үйлдвэрлэдэг/ борлуулдаг барааны төрөл]-ийг албан ёсоор үйлдвэрлэдэг/борлуулдаг бөгөөд, үүгээр [оруул: тендерт оролцогчийн бүтэн нэр] компанид бидний үйлдвэрлэсэн/борлуулсан [оруул: барааны нэр ба товч тодорхойлолт], барааг санал болгосон тендер ирүүлж, улмаар хэлэлцээр хийн гэрээ байгуулахыг зөвшөөрч байна.

Бид дээр дурдсан компанийн санал болгосон барааны хувьд Гэрээний ерөнхий нөхцөлийн 14-д заасны дагуу чанарын баталгааг бүрэн гаргаж байна.

Үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

5. Чадварын мэдээлэл ирүүлэх маягтууд

МАЯГТ №: ТШМ-5А

Санал болгож буй туслан гүйцэтгэгч

	Зүйл	Туслан гүйцэтгэгчийн нэр	Бүртгэгдсэн газар болон чадавхи

Ижил төрлийн гэрээ гүйцэтгэсэн туршлага

Тендерт оролцогч эсхүл түншлэлийн гишүүний нэр

Гэрээ тус бүрээр маягтыг бөглөнө.

1.	Гэрээний дугаар	
	Гэрээний нэр	
	Улсын нэр	
2.	Захиалагчийн нэр	
3.	Захиалагчийн хаяг	
4.	ТББ-д тодорхойлсон гэрээтэй холбогдох ижил төрлийн болон бусад онцлог	
5.	Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох)	<input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн
6.	Гэрээ/туслан гүйцэтгэх гэрээ/түншлэлийн хувьд ногдох гэрээний дүн/-ний үнийн дүн (гэрээ байгуулагдах эсхүл дуусгавар болсон үеийн мөнгөний нэгжээр илэрхийлсэн гэрээний дүн байна)	Мөнгөний нэгж Мөнгөний нэгж Мөнгөний нэгж
7.	Гэрээний дүн: _____;	Туслан гүйцэтгэх гэрээ: _____; Түншлэлийн хувьд ногдох гэрээний дүн: _____;
8.	Гэрээ байгуулсан/дуусгавар болсон огноо	
9.	Гэрээ нь хуваарыт хугацаанаас _____ сарын өмнө/дараа дууссан. (хэрэв хоцорч дууссан бол тайлбарлах)	
10.	Гэрээ нь гэрээний үндсэн үнийн дүнгээс _____ дутуу/илүү дүнгээр дуусгавар болсон. (хэрэв илүү гарсан бол тайлбарлах)	
11.	Техникийн тусгай шаардлагууд.	
12.	Нийт гэрээний үнийн дүнд туслан гүйцэтгэх гэрээгээр гүйцэтгэсэн дундаж хувийн жин, тухайн эх сурвалжийг тусгах.	

Нэгдсэн хүснэгт: Одоо хэрэгжиж буй гэрээ

Тендерт оролцогч эсхүл түншлэлийн гишүүний нэр

Тендерт оролцогч болон түншлэлийн гишүүн бүр өөрсдийн хэрэгжүүлж буй буюу одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ. Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаarahгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээг дуусгахаар төлөвлөсөн хугацаа	Дараагийн 6 сард нэхэмжлэх үнийн дүнгийн сарын дундаж
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Санхүүгийн чадавхи

Тендерт оролцогч эсхүл түншлэлийн гишүүний нэр
--

Тендерт оролцогч түншлэлийн гишүүн бүрийг оролцуулан ТОӨЗ-ны 18.2 (а) заалт болон түүнд харгалзахТШХ-д заасан шаардлагыг хангаж буйгхаруулсан санхүүгийн мэдээллийг ирүүлнэ.Тендерт оролцогч эсхүл түншлэлийн гишүүн бүр энэ маягтын дагуу өөрийн холбогдох мэдээллийг ирүүлнэ.Шаардлагатай бол банкны мэдээллийн хүснэгтийг тус тусдаа бөглөнө.Татварын албандаа тушаасан (захиалагч шаардсан бол аудитаар баталгаажуулсан байх) санхүүгийн тайланг нотлох баримт болгон энд хавсаргана.

Банк	Банкны нэр	
	Банкны хаяг	
Утас	Холбоо барих ажилтны нэр, албан тушаал	
Факс	Телекс	

Сүүлийн (**ТШХ-д заасан тоо**)хүртэлхжилийн хугацааны нийт хөрөнгө болон эх үүсвэрийг төгрөгөөр (хөрвүүлэх ханш нь тухайн жил бүрийн эцсийн байдлаар мөрдөгдөж байсан Монгол банкны зарласан ханш байна) илэрхийлнэ.

Санхүүгийн мэдээлэл /сая/	Сүүлийн (ТШХ-д заасан тоо) хүртэлх жилийн хугацаанд					Төлөвлөсөн: Дараагийн 2 жилийн хугацаанд	
	5	4	3	2	1	1	2
1. Нийт хөрөнгө							
2. Эргэлтийн хөрөнгө							
3. Нийт өглөг							
4. Эргэлтийн өглөг							
5. Татварын өмнөх ашиг							
6. Татварын дараах ашиг							

Санал болгож буй санхүүгийн эх үүсвэр буюу ТОӨЗ-ны 18.2 (а) заалт болон түүнд харгалзах ТШХ-д заасан шаардлагыг ханган гэрээг гүйцэтгэх явцад хүрэлцэхүйц эргэлтийн хөрөнгийн эх үүсвэртэйг харуулсан хөрвөх хөрөнгө, зээл авах боломж буюу зээлжих баталгаажсан эрх болон бусад санхүүгийн хэрэгслийг тодорхойлно.

Эргэлтийн хөрөнгө, санхүүгийн бусад эх үүсвэр	Дүн
1.	
2.	

3.	
4.	

ТОӨЗ-ны 18.2 (а) заалт болон түүнд харгалзах ТШӨХ-дзаасан хугацааны (тендер оролцогч эсхүл түншлэлийн гишүүн бүр) аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан, түүнд хийсэн тайлбарыг хавсаргана.

Хэрэв тендерт оролцогчийн улсын хуулиар аудитын баталгааг шаарддаггүй бол хувийн байгууллагын санхүүгийн тайланг эрх бүхий бүртгэгдсэн нягтлан бодогч болон татварын байгууллагын тодорхойлолтын хүулбарыг хавсаргана.

Ажиллах хүчний чадавхи

Тендерт оролцогчийн нэр

Тендерт оролцогч нь гэрээний удирдлага болон хэрэгжилтийг хариуцан ажиллахтай холбогдох ур чадвар, мэргэжлийн шаардлагыг хангасан, хамгийн багадаа 2 хүний нэрийг албан тушаал тус бүрт дэвшүүлнэ. Нэр дэвшигч бүрийн ажлын туршлагын талаарх мэдээллийгтус тусад нь гаргаж ирүүлнэ.

Тендерт оролцогч нь гэрээг удирдах, хэрэгжилтийн зохион байгуулах хувилбарт нэр дэвшигчийн ажлын туршлага, ур чадварын талаарх мэдээллийг мөн ирүүлнэ.

1.	Албан тушаал
	Үндсэн нэр дэвшигчийн нэр
	Хувилбарт нэр дэвшигчийн нэр
2.	Албан тушаал
	Үндсэн нэр дэвшигчийн нэр
	Хувилбарт нэр дэвшигчийн нэр
3.	Албан тушаал
	Үндсэн нэр дэвшигчийн нэр
	Хувилбарт нэр дэвшигчийн нэр
4.	Албан тушаал
	Үндсэн нэр дэвшигчийн нэр
	Хувилбарт нэр дэвшигчийн нэр

Шинэчилсэн үнийн хуваарь

Шинэчилсэн үнийн хуваарь нь гэрээний нэг хэсэг болох бөгөөд нийлүүлэгчийн ирүүлсэн тендер дэх үнийн хуваариас ялгаатай байвал түүнийг орлоно. Энэ шинэчилсэн үнийн хуваарь нь 33.1 дүгээр зүйлд заасны дагуу аливаа залруулга, тохируулгыг тусгана.

ХОЁРДУГААР ХЭСЭГ

**ТАВДУГААР БҮЛЭГ
БАРАА НИЙЛҮҮЛЭЛТЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

АГУУЛГА

1. БАРААНЫ НЭР ТӨРЛИЙН ЖАГСААЛТ БОЛОН НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ
2. ХОЛЬГОДОХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ БОЛОН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВААРЬ
3. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ
4. ЗУРАГ ТӨСӨЛ
5. ШАЛГАЛТ БОЛОН ТУРШИЛТ

1. Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарь

[Захиалагч энэхүү хүснэгтийн 1-7 хүртэлх баганыг, тендерт оролцогч 8 дугаар баганыг тус тус бөглөнө].

Нэр	Барааны тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг (Ажлын талбай)	Инкотермийн нэхцэлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Бараа нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Бараа нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа <i>(Тендерт оролцогч энэ баганыг бөглөнө)</i>
1	2	3	4	5	6	7	8
[Дугаар бичих]	[Барааны товч тодорхойлолтыг бичих]	[нэгжийн тоо ширхэгийг бичих]	[Хэмжих нэгжийг бичих]	[Бараа хүргэх газрын нэр]	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]

2. Холбогдох үйчилгээний жагсаалт ба гүйцэтгэлийн хуваарь

[Энэхүү хүснэгтийг захиалагч бөглөнө. Үйлчилгээг гүйцэтгэх дуусах хугацааг аль болох бодитой байхаар тооцон, бараа нийлүүлэх хугацаатай уялдуулан тогтооно].

1	2	3	4	5	6
Нэр төрөл	Үйлчилгээний талаархи тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	Үйлчилгээг гүйцэтгэх газар болон ажлын талбай	Үйлчилгээг гүйцэтгэж дуусгах огноо

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2019 оны шатахууны хэрэгцээ /лирт/

Д/д	Төрөл / Хэмжих нэгж	Шатахууны төрөл /литр/			
		Дизель	92	80	Автогаз
1	Архангай	560	1,200	1,640	-
2	Багануур	-	1,120	-	-
3	Баян-Өлгий	280	2,500	-	-
4	Баянхонгор	1,000	3,000	7,000	-
5	Булган	-	3,000	-	-
6	Говь-алтай	-	3,500	2,880	-
7	Говьсүмбэр	-	1,900	-	800
8	Дархан	2,500	200	-	-
9	Дорнговь	800	2,800	800	-
10	Дорнод	480	6,500	-	-
11	Дундговь	3,500	2,000	500	-
12	Завхан	-	5,000	600	-
13	Орхон	-	4,000	-	-
14	Өвөрхангай	-	8,000	500	-
15	Өмнөговь	560	3,000	400	-
16	Сүхбаатар	320	3,000	10,000	-
17	Сэлэнгэ	2,400	5,000	500	-
18	Төв	-	4,000	1,000	-
19	Увс	1,200	3,400	-	-
20	Ховд	-	5,000	600	-
21	Хөвсгөл	200	800	5,200	-
22	Хэнтий	500	3,600	3,600	-
	Аймаг нийт	14,300.00	72,520.00	35,220.00	800.00
	Улаанбаатар	82,000.0	82,000.0	-	-
	Компанийн нийт	96,300.0	154,520.0	35,220.0	800.0

ГУРАВДУГААР ХЭСЭГ

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

ГАРЧИГ

1. Нэр томъёо
2. Гэрээний баримт бичиг, мэдээллийг ашиглах, хяналт шалгалт явуулах
3. Захиалгыг өөрчлөх
4. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах
5. Туслан гүйцэтгэх гэрээ байгуулах
6. Барааны гарал үүслийн улс
7. Шалгалт, туршилт
8. Баглаа боодол
9. Барааны нийлүүлэлт болон баримт бичгийн бүрдүүлэлт
10. Зохиогчийн болон оюуны өмчийн эрх
11. Гүйцэтгэлийн баталгаа
12. Даатгал
13. Чанарын баталгаа, баталгаат засвар
14. Төлбөр
15. Үнэ
16. Хуваарийг сунгах
17. Алданги оногдуулах
18. Үүргээ биелүүлээгүйгээс гэрээг цуцлах
19. Төлбөрийн чадваргүй болсны улмаас гэрээг цуцлах
20. Захиалгачийн шаардлагаар гэрээг цуцлах
21. Маргааныг шийдвэрлэх
22. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал
23. Гэрээний үүргийг шилжүүлэх
24. Гэрээнд ашиглах хэл
25. Татвар, хураамж
26. Гарчиг
27. Үүргийн гүйцэтгэл

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

-
- | | |
|---------------------------|---|
| 1. Нэр томъёо | 1.1. Энэ гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.
Үүнд: |
| | <p>(а) “гэрээ”гэж захиалагч, нийлүүлэгчийн хооронд байгуулсан бараа нийлүүлэх гэрээг хэлнэ. Гэрээ нь талуудын гарын үсэг зурсан гэрээний маягт, түүнийг дагалдах хавсралт, бусад баримт бичгээс бүрдэнэ.</p> <p>(б) “гэрээний үнэ” гэж гэрээний дагуу гэрээний үүргээ бүрэн болон зохих хэмжээнд гүйцэтгэсний дагуу нийлүүлэгчид төлөх үнийг хэлнэ.</p> <p>(в) “бараа” гэж нийлүүлэгчээс захиалагчид гэрээний дагуу нийлүүлэх тоног төхөөрөмж, машин механизм болон бусад материалыг хэлнэ.</p> <p>(г) “бусад үйлчилгээ” гэж тээвэрлэлт, даатгал болон бусад дагалдах үйлчилгээ, угсралт, техникийн туслалцаа, сургалт зэрэг гэрээний дагуу нийлүүлэгчийн үзүүлэх аливаа дагалдах ажил, үйлчилгээ, Үүргийг хэлнэ.</p> <p>(д) “захиалагч” гэж барааг худалдан авч буй гэрээний тусгай нөхцөлд нэрлэсэн байгууллагыг хэлнэ.</p> <p>(е) “нийлүүлэгч” гэж гэрээнд заасан бараа, үйлчилгээг нийлүүлж буй этгээдийг хэлнэ.</p> <p>(ж) “ажлын талбай” гэж гэрээний тусгай нөхцөлд тодорхойлсон газрыг хэлнэ.</p> <p>(з) “хоног” гэж хуанлийн хоногийг хэлнэ.</p> |
| 2. Гэрээний баримт | 2.1. Нийлүүлэгч нь захиалагч бичгээр урьдчилан зөвшөөрөөгүй тохиолдолд гэрээ ба түүний нөхцөл, эдгээртэй холбогдуулж захиалагчийн өгсөн техникийн тодорхойлолт, зураг, загвар, дээж зэрэг мэдээллийг гэрээг гүйцэтгэхээр томилогдсон ажилтнаас бусад этгээдэд задлаж болохгүй. Гэрээг гүйцэтгэхээр томилогдсон ажилтныг зөвхөн түүний хариуцсан ажилд шаардлагатай мэдээллээр хангана. |
| | 2.2. Захиалагч бичгээр урьдчилан зөвшөөрөөгүй тохиолдолд, нийлүүлэгч 2.1-т дурдсан баримт бичиг болон мэдээллийг гэрээ гүйцэтгэхээс бусад зорилгоор ашиглахгүй. |
| | 2.3. 2.1-т дурдсан гэрээнээс бусад баримт бичиг захиалагчийн өмч хэвээр үлдэх ба хэрэв захиалагч хусвэл нийлүүлэгч гэрээний үүргээ гүйцэтгэж дуусмагц (бүх хувийг) захиалагчид буцааж өгнө. |
| | 2.4. Захиалагчний нийлүүлэгчийн гэрээний гүйцэтгэлд хамаарах данс, бүртгэлийг шалгах эрхтэй ба аудитор томилж эдгээр данс, бүртгэлд хөндлөнгийн шалгалт хийлгэх эрхтэй. |

- 3. Захиалгыг өөрчлөх**
- 3.1. Захиалагч нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээний срөнхий цар хүрээнд багтаан дор дурдсан нэг буюу түүнээс дээш зүйлийн захиалгыг хэдийд ч өөрчлөх эрхтэй. Үүнд:
 - (а) гэрээний дагуу нийлүүлэгдэх барааг захиалагчид зориулан тусгайлан үйлдвэрлэсэн байхаар зураг, зураг төсөл, техникийн тодорхойлолтыг өөрчлөх;
 - (б) тээвэрлэлтийн болон баглаа боодлын хэлбэр;
 - (в) барааг хүргэх газар.
 - 3.2. Нийлүүлэгч нь захиалгын өөрчлөлтийн (цаашид “өөрчлөлт” гэх) улмаас гэрээнд заасан бараа нийлүүлэх хугацаанд үзүүлэх нөлөөг (хэрэв нөлөөлөх бол) харгалзан түүний зардлын нарийвчилсан тооцоо, хэрэгжүүлэх хуваарийг гаргаж, өөрчлөлтийн мэдэгдлийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор захиалагчид танилцуулна.
 - 3.3. Захиалагч 3.2-т дурдсан нийлүүлэгчийн тооцоог үндэслэж өөрчлөлтийг бичгээр батлах ба ийнхүү баталгаажуулах хүrtэл нийлүүлэгч 3.1-д дурдсан өөрчлөлтийг гүйцэтгэхгүй.
 - 3.4. Харилцан тохиролцсон өөрчлөлт нь гэрээний хэсэг болох ба энэ өөрчлөлтөд гэрээний нөхцөл, болзول үйлчилинэ.
- 4. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах**
- 4.1. Энэхүү гэрээний 3 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд гэрээний нөхцөл, болзлыг засварлах, эсхүл өөрчилж болохгүй. Зайлшгүй шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг бичгээр үйлдэж талууд гарын үсэг зурна.
- 5. Туслан гүйцэтгэх гэрээ байгуулах**
- 5.1. Захиалагч урьдчилж бичгээр зөвшөөрөөгүй тохиолдол нийлүүлэгч гэрээ болон түүний аль нэг хэсгийг туслан гүйцэтгүүлэх зорилгоор туслан гүйцэтгэгч сонгож түүнтэй гэрээ байгуулж болохгүй.
 - 5.2. Нийлүүлэгч гэрээг хэрэгжүүлэхдээ сонгосон аливаа туслан гүйцэтгэгч нь өөрийн хариуцсан ажил үүрэгт ногдох гэрээний холбогдох нөхцөл, болзлыг бүрэн биелүүлэхийг батламжилна.
- 6. Барааны гарал үүслийн улс**
- 6.1. Гэрээний дагуу нийлүүлэх бараа нь аль ч улсаас гарал үүсэлтэй байж болно.
 - 6.2. Барааны гарал үүслийн улс гэдэгт барааг олборлосон, ургуулсан, бойжуулсан, эсхүл хийж бүтээсэн газрыг хэлнэ. Хийж бүтээсэн гэж үйлдвэрлэсэн, боловсруулсан, эсхүл эд ангиудын дийлэнхийг угсарч, энэ эд ангиудын үндсэн шинж чанар, зориулалт, эсхүл ашиглалтын хэлбэрээс илт өөр арилжааны шинэ бараа гаргаж ирэхийг хэлнэ.

- 7. Шалгалт болон туршилт**
- 7.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч, эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, туршилт хийх эрхтэй. Гэрээний тусгай нөхцөлд эсвэл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. Захиалагч шалгалт, туршилт хийхээр томилсон төлөөлөгч(д)ийг нийлүүлэгчид бичгээр мэдэгдэнэ.
 - 7.2. Шалгалт, туршилтыг нийлүүлэгчийн, эсхүл түүний туслан гүйцэтгэгчийн эзэмшил газар, барааг хүргэх газар болон эцсийн цэгт явуулж болно. Шалгалт, туршилтыг нийлүүлэгчийн, эсхүл түүний туслан гүйцэтгэгчийн эзэмшил газар явуулсан тохиолдолд захиалагчийг шаардлагатай байгууламж, зураг, үйлдвэрлэлийн өгөгдөл болон бусад туслалцаагаар үнэ төлбөргүй хангана.
 - 7.3. Шалгалт, туршилтаар бараа нь техникийн тодорхойлолтыг хангаагүй тохиолдолд захиалагч тус бараанаас татгалзах эрхтэй ба нийлүүлэгч тус барааг үнэ төлбөргүй солих эсвэл техникийн тодорхойлолттой нийцүүлэх бүхий л арга хэмжээ авна.
 - 7.4. Барааг тээвэрлэхээс өмнө захиалагч, эсхүл түүний төлөөлөгч шалгасан, туршсан байх нь Монгол Улсад орж ирсний дараа түүнийг дахин шалгах, турших болон шаардлагатай тохиолдолд татгалзаж болох захиалагчийн эрхийг хөндөхгүй.
 - 7.5. Энэ зүйлийн аль ч нөхцөл, болзол нийлүүлэгчийг гэрээний баталгаат засварын болон бусад үүргээс чөлөөлөхгүй.
- 8. Баглаа боодол**
- 8.1. Нийлүүлэгч барааг эцсийн цэг хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудахаас урьдчилан сэргийлэх баглаа боодлоор гэрээнд заасны дагуу хангана. Баглаа боодол нь тээвэрлэлтийн үсийн хатуу нөхцөл, тээвэрлэлт болон ил хадгалалтын үсийн халуун, хүйтэн болон давс, хур тундас зэргийг хангалттай тээвэрлэхээр байна. Баглаа, боодлын хэмжээ, жинг сонгоходо барааг хүргэх эцсийн цэгийн алслагдсан байдал, түүнчлэн тээвэрлэлтийн цэг бүрт ачих, буулгах хангалттай төхөөрөмж байгаа эсэх зэрэг хүчин зүйлийг харгалзсан байна.
 - 8.2. Баглаа боодол, түүний дотор, гадна талд тэмдэглэгээ хийх, баримт бичигийг бэлтгэхдээ гэрээнд, нэн ялангуяа гэрээний тусгай нөхцөлд заасан шаардлага болон захиалагчийн тухайн үед өгөх зааварчилгааг чанд мөрдөнө.
- 9. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт**
- 9.1. Нийлүүлэгч техникийн тодорхойлолтын шаардлагын дагуу барааг нийлүүлнэ. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулга, хувилбарыг хэрэглэнэ. Нийлүүлэгч гэрээний тусгай нөхцөлд заасан бол түүний дагуу тээврийн болон бусад бичиг баримтыг бэлтгэж бүрдүүлнэ.
 - 9.2. Гэрээнд хэрэглэсэн CIP /СИП/, EXW /ИКСБ/, FOB /ФОБ/, FCA/ФСА/, CIF /СИФ/ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.

- 10. Зохиогчийн болон оюуны өмчийн эрх**
- 10.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглах явцад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн тохиолдолд гомдлыг нийлүүлэгч барагдуулж холбогдон гарах зардлыг хариуцна.
- 11. Гүйцэтгэлийн баталгаа**
- 11.1. Нийлүүлэгч гэрээний тусгай нөхцөлд заасан мөнгөн дүн бүхий гүйцэтгэлийн баталгааг гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор захиалагчид өгнө.
- 11.2. Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн гүйцэтгэж чадаагүйгээс захиалагчид учрах хохирлыг нехөж барагдуулахад уг баталгаа зориулагдана. Гэрээний гүйцэтгэлийг ГЕН-ийн 16.2-ын дагуу сунгахад нийлүүлэгч мөн хугацаагаар гүйцэтгэлийн баталгааны хүчинтэй хугацааг сунгана.
- 11.3. Гүйцэтгэлийн баталгаа нь ТОӨЗ-ны 16 дугаар зүйлд заасан валютаар гаргасан банкны баталгаа, Засгийн газрын бонд эсхүл Засгийн газрын хүлээн зөвшөөрсөн үнэт цаасны хэлбэрээр гаргасан баталгаа байна.
- 11.4. Нийлүүлэгч гэрээний дагуу гүйцэтгэх ажлыг дуусгавар болгосноос хойш 30 хоногийн дотор захиалагч гүйцэтгэлийн баталгааг хүчингүй болгоно.
- 12. Даатгал**
- 12.1. ГТН-д тусгайллан өөрөөр заагаагүй бол барааг үйлдвэрлэх, худалдаж авах, тээвэрлэх, нийлүүлэх, хадгалах, болон хүргэх үед гарч болох алдагдал, гэмтэлтэй холбоотой эрсдэлээс хамгаалж бүх барааг ГТН-д заасан хэлбэрээр инкотермсийн нөхцлийн дагуу даатгуулна.
- 13. Чанарын баталгаа, баталгаат засвар**
- 13.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх бараа нь шинэ, урьд өмнө ашиглагдаагүй, гэмтэл согогтүй бөгөөд хамгийн суулийн буюу өнөөгийн загварын, техникийн тодорхойлолтод бүрэн нийцсэн орчин үеийн шинэлэг ололтуудыг агуулсан байна. Өөрийн болон туслан гүйцэтгэгчийн бараа нийлүүлэхэд ашиглах бүх материал, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл зэрэг нь шинэ, сайн чанарын болон зориулалтынх байна гэдгийг нийлүүлэгч баталгаажуулна.
- 13.2. ГТН-д өөрөөр заагаагүй бол баталгаат засвар нь барааг хүргэж, ашиглалтад хүлээлгэн өгснөөс хойш 12 сар, эсхүл барааны гарал үүслийн улсын боомтоос ачсан өдрөөс хойш 18 сар гэсэн хугацааны аль эрт дуусах хугацаанд хүчинтэй байна.
- 13.3. Захиалагч энэхүү баталгаатай холбогдох гомдлыг нийлүүлэгчид бичгээр шуурхай мэдэгдэнэ.
- 13.4. Нийлүүлэгч энэхүү мэдэгдлийг хүлээн аваад гэмтэл согогтой бараа, эсхүл түүний эд ангийг үнэ төлбөргүй, шуурхай засварлах буюу солино.
- 13.5. Захиалагч нь 13.2 заасны үл харгалзан, 13.4-т заасны дагуу гэмтэл согогийг арилгаснаас хойш 12 сарын дотор засварласан бараанд энэ төрлийн гэмтэл согог дахин гарсан тухай бичгээр мэдэгдэл ирвэл уг гэмтэл согогийг үнэ төлбөргүй шуурхай арилгана.

- 13.6. Хэрэв нийлүүлэгч гэмтэл согог гарсан мэдэгдэл хүлээн аваад гэрээний дагуу түүнийг арилгахгүй бол захиалагч өөрөө нийлүүлэгчийн зардлаар уг гэмтэл согогийг арилгах эрхтэй. Энэ зүйлд заасны дагуу нийлүүлэгчийн гаргах баталгаа нь гэрээнд заасан захиалагчийн бусад эрх, үйл ажиллагааг хязгаарлахгүй.
- 14. Төлбөр**
- 14.1. Гэрээний дагуу нийлүүлэгчид төлөх төлбөрийн хэлбэр, нөхцөлийг ГТН-д дурдана.
- 14.2. Нийлүүлэгч нь гэрээний үүргээ бүрэн биелүүлсний дараагаар төлбөр хийхийг хүссэн хүсэлтийг төлбөрийн нэхэмжлэх болон ГЕН-ийн 9 дүгээр зүйлд заасан баримт бичгийн хамт захиалагчид хүргүүлнэ.
- 14.3. ГТН-д өөрөөр заагаагүй бол захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээнавснаас хойш 30 хоногийн дотор шуурхай хийнэ.
- 14.4. Гэрээний дагуу нийлүүлэгчид хийх төлбөрийг тендерийн маягтад дурдсан валютаар хийнэ.
- 15. Үнэ**
- 15.1. Гэрээний дагуу хүргэсэн бараа болон гүйцэтгэсэн үйлчилгээний үнийг нэхэмжлэхдээ нийлүүлэгч өөрийн тендерт санал болгосон үнийг баримтлана. ГТН-ийн үнэ тохируулах нөхцөлийн дагуу үнийг тохируулах, эсхүл ГЕН-ийн 3 дугаар зүйлийн дагуу захиалгыг өөрчлөхөд тендерт санал болгосон үнэ өөрчлөгдвэл, өөрчлөгдсөн үнийг баримтлана.
- 16. Хуваарийг сунгах**
- 16.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
- 16.2. Нийлүүлэгч дараах тохиолдолд бараа нийлүүлэлтийн хуваарийг сунгах тухай хүсэлт гаргаж болно. Үүнд:
- (а) захиалагч ГЕН-ийн 3 дугаар зүйлд заасны дагуу захиалгыг өөрчилсөн;
 - (б) захиалагчаас гаргаж өгөх материал, зураг, эсхүл үйлчилгээ хугацаа хоцорсон (үйлчилгээ гэдэгт гэрээний дагуу захиалагчийн гаргах зөвшөөрөл, баталгаа орно);
 - (в) ГЕН-ийн 22 дугаар зүйлд заасан гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүсвэл;
 - (г) захиалагчийн өгсөн захиалгаас шалтгаалан ажлын гүйцэтгэл хойшилсон.
- Нийлүүлэгч хугацаа хоцрохоос урьдчилан сэргийлэхийн тулд бололцоотой бүхнийг хийсэн гэдгийг захиалагчид нотлон харуулах үүрэгтэй. Хугацаа хоцролтын шалтгааныг арилгах, даван туулах арга замуудыг талууд хэлэлцэнэ.
- 16.3. Гүйцэтгэгч 16.2-т заасан нөхцөл байдал бий болсны улмаас бараа нийлүүлэлтийн хуваарь ямар нэг байдлаар хоцорч болох тухай захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдээгүй, эдгээр нөхцөл байдал бий болсныг нотлон харуулаагүй тохиолдолд 16.2-ыг үл харгалзах ба хуваарийг сунгахгүй.

17. Алданги оногдуулах	17.1.	Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг уг хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэх ёсгүй. Дээд хэмжээнд хүрсэн тохиолдолд захиалагч ГЕН-ийн 18 дугаар зүйлийн дагуу цуцлах тухай асуудлыг хөндөж болно.
18. Үүргээ биелүүлээгүйгээс гэрээг цуцлах	18.1.	<p>Захиалагч дор дурдсан нөхцөл байдлын аль нэг нь үүссэн тохиолдолд гэрээний дагуу зөрчлийг арилгах бусад арга хэрэгслийг ашиглалгүйгээр нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн цуцлах эрхтэй. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> (а) нийлүүлэгч аль нэг болон бүх барааг гэрээнд заасан эсвэл ГЕН-ийн 16 дугаар зүйлийн дагуу сунгасан хугацаанд хүргэж чадаагүй; (б) нийлүүлэгчийн ирүүлсэн бараа нь техникийн тодорхойлолтын шаарлага хангагүй бөгөөд гэрээний бусад үүргээ биелүүлээгүй; (в) нийлүүлэгч 18.1.(а), 18.1.(б)-д заасан нөхцөл байдал үүссэн тухай мэдэгдлийг захиалагчаас хүлээн аваад 10 хоногийн дотор (захиалагч үүнээс урт хугацаа заах эрхтэй) алдаагаа залруулаагүй; (г) нийлүүлэгч тендер шалгаруулалтад оролцох, гэрээ байгуулах, хэрэгжүүлэхдээ авлигат, залилан мэхлэх зохиомол тохиролцоо хийх болон айлган сүрдүүлэх үйлдэлд холбогдоныг шүүх, эсхүл эрх бүхий байгууллага тогтоосон бол захиалагч түүнд гэрээ байгуулах эрх олгохгүй бөгөөд нэгэнт гэрээ байгуулах эрх олгогдсон, эсхүл гэрээ байгуулагдсан бол түүнийг цуцална.
	18.2.	18.1-ийн дагуу гэрээг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн цуцалсан тохиолдолд захиалагч нийлүүлэгдээгүй барааг тохиромжтой гэж үзсэн нөхцөлөөр захиалагч худалдан авах эрхтэй ба үүнтэй холбогдон гарсан нэмэлт зардлыг нийлүүлэгч хариуцна. Энэ зүйлийг үл харгалzan нийлүүлэгч гэрээний цуцлагдаагүй хэсгийг үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.
19. Төлбөрийн чадваргүй болсны улмаас гэрээг цуцлах	19.1.	Нийлүүлэгч дампуурах, эсхүл бусад хэлбэрээр төлбөрийн чадваргүй болсон бол захиалагч нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээг хэдийд ч цуцлах эрхтэй. Ингэхдээ захиалагч нийлүүлэгчид учирсан хохирлыг нөхөн төлөхгүй. Гэвч ийнхүү цуцалсан нь захиалагчид үүссэн эсвэл ирээдүйд үүсэх аливаа эрхийг, хөндөхгүй.
20. Захиалагчийн шаардлагаар гэрээг цуцлах	20.1.	Захиалагч шаардлагатай тохиолдолд нийлүүлэгчид бичгээр мэдэгдэж гэрээг хэдийд ч бүхэлд нь эсхүл хэсэгчлэн цуцлах эрхтэй. ² Захиалагч мэдэгдэлдээ өөрийн шаардлагаар гэрээг цуцлах болсон үндэслэл болон гэрээний аль хэсгийг, хэзээнээс цуцалж буйг заавал дурдана.
	20.2.	Мэдэгдэл нийлүүлэгчид очсоноос хойш 30 хоногийн дотор тээвэрлэхэд бэлэн болсон барааг захиалагч гэрээнд заасан үнэ болон бусад нөхцөлөөр худалдаж авна. Үлдэх барааны хувьд захиалагч дор дурдсан сонголтын аль нэгийг, эсхүл хоёуланг хэрэгжүүлнэ. Үүнд:
		(а) үлдэх барааны одоогоор бэлэн болсон аливаа хэсгийг гэрээнд

² Захиалагч гэрээг цуцлах шийдвэрийг холбогдох дээд шатны байгууллагын зөвшөөрөлтэйгээр зөвхөн зайлшгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд гаргана.

заасан үнэ, бусад нөхцөлөөр авах, болон/эсхүл

- (б) үлдэх барааг цуцлах ба нийлүүлэгчийн хагас бэлэн болсон бараа, гэрээг хэрэгжүүлэх зорилгоор худалдаж авсан материал, эд ангийн хэлэлцэж тохирсон үнийг төлнө. Энэ дунд захиргааны зардлын болон ашгийн зохих хэмжээг оруулж тооцно.
- 21. Маргааныг шийдвэрлэх** 21.1. Захиалагч болон нийлүүлэгчийн хооронд гэрээтэй холбогдож гарч болох маргааныг зөвшилцэл болон албан бус хэлэлцээрээр шийдэхийг хичээнэ.
- 21.2. Дээрх хэлэлцээр 30 хоног үргэлжлэхэд гэрээний маргааныг талууд шийдэж чадахгүй бол аль ч тал ГТН-д заасны дагуу шүүхэд хандах эрхтэй.
- 22. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал** 22.1. Дайн, иргэний бослого, түймэр, үер, халдварт өвчин, газар хөдлөлт, хорио цээр, тээврийн хориг болон бусад гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэнээс захиалагч, эсхүл нийлүүлэгч, эсхүл туслан гүйцэтгэгчийн гэрээний үүргийн гүйцэтгэл хугацаа хоцорсон бол ГЕН-ийн 16 дугаар зүйлийн дагуу түүнийг гүйцэтгэх хугацааг сунгана.
- 22.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэн тохиолдолд нийлүүлэгч нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдэнэ. Захиалагч бичгээр өөрөөр зааварлаагүй бол нийлүүлэгч гэрээний үүргээ боломжтой хэмжээнд үргэлжлүүлэн гүйцэтгэж, гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлаас үл шалтгаалан гэрээг хэрэгжүүлэх боломжит арга замыг хайна.
- 23. Гэрээний үүргийг шилжүүлэх** 23.1. Ямарч тохиолдолд гэрээний үүргийг гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.
- 24. Гэрээнд ашиглах хэл** 24.1. Нийлүүлэгч ГТН-д заасан гэрээнд ашиглах хэлийг бүрэн ойлгох мэдлэгтэй гэдгээ үүгээр баталж байна. Гэрээ түүнд холбогдох баримт бичиг, харилцах бичиг баримт нь энэ хэл дээр байна.
- 24.2. 24.1-д заасан хэл рүү орчуулах зардал болон орчуулгын үнэн зөвийг нийлүүлэгч хариуцна.
- 25. Татвар болон хураамж** 25.1. Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна оногдуулдаг бүх төрлийн татвар, хураамжийг нийлүүлэгч бүрэн хариуцна.
- 26. Гарчиг** 26.1. Гэрээний бүлэг, зүйл болон бусад хэсгийн гарчиг нь зөвхөн тайлбарын шинжтэй бөгөөд гэрээний хэсэг болохгүй.
- 27. Үүргийн гүйцэтгэл** 27.1. Аль нэг тал нь гэрээний үүргээ гүйцэтгэхийг хатуу шаардаагүй нь нөгөө талын уг үүргийг биелүүлэхгүй байх шалтгаан болохгүй.

1. Алданги оногдуулах (ГЕН - 17) 17.1 Алданги оногдуулах хувь: **Хоногийн 0.01 хувь**
Алдангийн нийт дүн: **Гэрээний үнийн дүнгийн 10.0 хувь**
2. Маргааныг шийдвэрлэх (ГЕН - 21) 21.0 Талуудын хооронд гарсан маргааныг Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.
-

ДОЛООДУГААР БҮЛЭГ

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

3. Тодорхойлолт (ГЕН - 1)	1.1.(д) 1.1 (ж)	Захиалагч нь <i>Монгол шуудан ХК</i> <i>Улаанбаатар хот, 21 аймгийн төв /аймгийн төв цэгээс 2 километрийн радиус дотор салбартай байх/, бүх сумуудад гэрээний хавсралтад заасан үнээр 1 жилийн хугацаанд шатахуун нийлүүлнэ.</i>
4. Шалгалт туршилт (ГЕН - 7)	7.0	<i>Нийлүүлсэн бүтээгдэхүүний чанар нь Монгол улсад мөрдөгддөг стандарт болон техникийн нөхцөлд тохирсон байна.</i>
5. Баглаа боодол (ГЕН - 8)	8.0	<i>“Шаардлагагүй”</i>
6. Барааг хүргэх болон бичиг баримтын бүрдүүлэлт (ГЕН - 9)		<i>Улаанбаатар хот, аймгийн худалдан авагчийн болон нийлүүлэгчийн нягтлангууд нь нийлүүлсэн шатахууны тоо хэмжээ, гүйцэтгэлийн дүнг улиралд 1 удаа тооцоо нийлэн зөрүүг баталгаажуулан акт үйлдээж тооцно.</i>
7. Гүйцэтгэлийн баталгаа (ГЕН - 11)	11.1	<i>Гүйцэтгэлийн баталгаа гэрээний үнийн 5 хувьтай тэнцэх дүнтэй байна.</i>
8. Баталгаат засвар (ГЕН-13)	13.0	<i>“Шаардлагагүй”</i>
9. Төлбөр (ГЕН 14)		<i>ГЕН-ийн 14 дүгээр зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:</i> <ul style="list-style-type: none">• <i>Унийн санаалд НӨАТ багтсан байх,</i>• <i>Гэрээний үнэ тогтолцол байна,</i>• <i>Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойши актаар баталгаажсны дараа хийнэ. Урьдчилгаа төлбөр олгохгүй.</i> <i>Гүйцэтгэлийн төлбөр:</i> Ирсэн барааны гэрээний үнийн 100 хувьтай тэнцэх дүнг ГЕН-ийн 9 дүгээр зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө. Алданги оногдуулах хувь: <i>Хоногийн 0.01 хувь</i> Алдангийн нийт дүн: <i>Гэрээний үнийн дүнгийн 10.0 хувь</i> Улирал бүр тооцоо нийлжэ, гэрээний үнийн дунд зөрүү үүссэн бол тухайн зөрүү үнийн дунг ажлын 5 хоногт багтаан захиалагчид буцаан шилжүүлнэ. Заасан хугацаанд шилжүүлээгүй бол гүйцэтгээгүй үнийн дүнгийн 0.01 хувиар хоногт тутам алданги тооцно.
10. Алданги оногдуулах (ГЕН - 17)	17.1	Алданги оногдуулах хувь: <i>Хоногийн 0.01 хувь</i> Алдангийн нийт дүн: <i>Гэрээний үнийн дүнгийн 10.0 хувь</i> Улирал бүр тооцоо нийлжэ, гэрээний үнийн дунд зөрүү үүссэн бол тухайн зөрүү үнийн дунг ажлын 5 хоногт багтаан захиалагчид буцаан шилжүүлнэ. Заасан хугацаанд шилжүүлээгүй бол гүйцэтгээгүй үнийн дүнгийн 0.01 хувиар хоногт тутам алданги тооцно.
11. Маргааныг шийдвэрлэх (ГЕН - 21)	21.0	<i>Талуудын хооронд гарсан маргааныг Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.</i>

НАЙМДУГААР БҮЛЭГ

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [нийлүүлэгчийн нэр] (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож оны сарын -ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “бараа” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр]

(цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь нэр төрлийн барааг оны дугаар сарын -нээс оны дугаар сарын -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг³;
Тендер ба үнийн хуваарь;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Гэрээний тусгай нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.
6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

³ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАТАЛГААНЫ МАЯГТ (БАНКНЫ БАТЛАН ДААЛТ)

Монгол шуудан ХК-д

[Гүйцэтгэгчийн нэр] нь (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нь **[Гэрээний нэр ба ажлын төвч тодорхойлолт]** (цаашид “тэрээ” гэх) ажлыг гүйцэтгэх болсонтой ХОЛБОГДУУЛАН,

Гүйцэтгэгч гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож захиалагчийн хүлээн зөвшөөрөх банкны гаргасан дор дурдсан дүнтэй батлан даалтыг захиалагчид ирүүлэхийг дээрх гэрээнд заасантай ХОЛБОГДУУЛАН,

[Банкны нэр] (цаашид “Банк” гэх) нь дараах батлан даалтыг гаргаж байна:

Банк нь гүйцэтгэгчийн нэрийн өмнөөс **[баталгааны дүн тоогоор, төгрөг]/[дүн үсгээр, төгрөг]**⁴ –ээс хэтрэхгүй мөнгөн дүнтэй төлбөрийг **[захиалагчийн нэр]**(цаашид “захиалагч” гэх)-ийн өмнө хариуцаж, гүйцэтгэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай захиалагчийн бичгээр гаргасан анхны шаардлагыг хүлээн авсан даруй үл маргалдах журмаар энэхүү төлбөрийг хийх үүрэг хүлээж байна. Ингэхдээ дээр дурдсан **[баталгааны дүн тоогоор, төгрөг]/[дүн үсгээр, төгрөг]**-ийн хүрээнд захиалагчийн шаардсан аливаа дүнг ямарваа нэгэн нотолгоо, үндэслэл болон тайлбар шаардахгүй.

Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний нөхцөл болзол, эсхүл түүний дагуу гүйцэтгэх ажил, эсхүл гэрээний бичиг баримтад оруулж болох аливаа өөрчлөлт, нэмэлт нь энэ батлан даалтын дагуу банкны хүлээсэн үүргийг хөндөхгүй ба дээрх өөрчлөлт, нэмэлтийн талаарх аливаа мэдэгдлийг ирүүлэх шаардлагагүй.

Энэ баталгаа нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш /огноог оруулах/ хугацаанд хүчинтэйбайна.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Банкны эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Албан тушаал, нэр:

Банкны тамга

Огноо:

Хаяг:

⁴ Энэ дүнг баталгаа гаргагч бөглөх бөгөөд гэрээнд заасан гэрээний үнийн хувийг илэрхийлнэ. Энэ нь гэрээний валютаар, эсхүл захиалагчийн хүлээн зөвшөөрсөн чөлөөтэй хөрвөх валютаар илэрхийлэгднэ.

УРЬДЧИЛГАА ТӨЛБӨРИЙН БАТАЛГААНЫ МАЯГТ (БАНКНЫ БАТЛАН ДААЛТ)

Монгол шуудан ХК-д

[Гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) оны ... дугаар сарын ...-ний өдрийн ... тоот *[Гэрээний нэр ба ажлын товч тодорхойлолт]* гэрээ (цаашид “гэрээ” гэх)-ний ерөнхий нөхцөлийн 48 дугаар зүйлийн дагуу хүлээсэн үүргээ амжилттай биелүүлэхээ баталж *[Захиалагчийн нэр]*-ийн өмнө хариуцлага хүлээж *[Баталгааны мөнгөн дүн]/[үсгээр]*⁵-ийн банкны баталгаа ирүүлэхтэй ХОЛБОГДУУЛАН,

[Банк нэр] (цаашид “Банк” гэх) нь гүйцэтгэгчийн нэрийн өмнөөс *[баталгааны дүн тоогоор, валюты/дүн үсгээр, валюты]*⁶-ээс хэтрэхгүй мөнгөн дүнтэй төлбөрийг захиалагчийн өмнө хариуцаж, гүйцэтгэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай захиалагчийн бичгээр гаргасан анхны шаардлагыг хүлээн авсан даруй үл маргалдах журмаараа энэхүү төлбөрийг хийх үүрэг хүлээж батлан даалт гаргаж байна.

Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний нөхцөл болзол, түүний дагуу гүйцэтгэх ажил, гэрээний бичиг баримтад оруулж болох аливаа өөрчлөлт, нэмэлт нь энэ батлан даалтын дагуу банкны хүлээсэн үүргийг хөндөхгүй ба дээрх өөрчлөлт, нэмэлтийн талаарх аливаа мэдэгдлийг ирүүлэх шаардлагагүй.

Энэхүү баталгаа нь гэрээний нөхцөлийн дагуу захиалагчид дээр дурдсан дүнтэй ижил төлбөр эргэн төлөгдөх өдөр /огноог оруулах/ хүртэлхүчин төгөлдөр байна.

Банкны эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Албан тушаал, нэр:

Банкны тамга:

Огноо:

Хаяг:

⁵ Энэ дунг банк, эсхүл санхүүгийн байгууллага бөглөх бөгөөд урьдчилгаа төлбөрийн үнийн хувийг илэрхийлнэ. Энэ нь урьдчилгаа төлбөрийн валютаар, эсхүл захиалагчийн хүлээн зөвшөөрсөн чөлөөтэй хөрвөх валютаар илэрхийлэгдэнэ.

⁶ Энэ дунг баталгаа гаргагч бөглөх бөгөөд гэрээнд заасан гэрээний үнийн хувийг илэрхийлнэ. Энэ нь гэрээний валютаар, эсхүл захиалагчийн хүлээн зөвшөөрсөн чөлөөтэй хөрвөх валютаар илэрхийлэгдэнэ.

ТЕНДЕРИЙН УРИЛГА

2019-05-27

Тендер шалгаруулалтын нэр, дугаар: Шатахуун нийлүүлэх” гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, МШ/201901130

“Монгол шуудан” ХК эрх бүхий тендерт оролцогчдоос “Шатахуун нийлүүлэх” гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, МШ/201901130 хялбаршуулсан цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: *Сүүлийн 2 жилийн борлуулалтын дундаж дүн нь санал болгож буй үнийн дүнгээс багагүй байх (2017 он, 2018 он)*

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: *2 жил (2017 он, 2018 он)*

Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: *Сүүлийн 2 жил (2017 он, 2018 он)*.

Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: *1 буюу түүнээс дээш удаа санал болгож буй үнийн дүнгийн 100 хувиас багагүй хэмжээний ажлыг хэрэгжүүлсэн байх*

Гүйцэтгэгчээр ажилласан байх жилийн тоо: *2 жил (2017 он, 2018 он)*

Ашигтай ажилласан байх жилийн тоо: *Хоёр жил (2017 он, 2018 он)*

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: Шаардлагатай

Үнийн саналд НӨАТ багтсан байх,

Тендерийн төрөл: *Хялбаршуулсан цахим*

Тендерийн хамт **10,000,000 /арван сая/** төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийн баталгааны хүчинтэй хугацаа нь **2019 оны 08 дугаар сарын 9-ний өдрийг дуустал.**

Тендерийг **2019 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 10 цаг 00 минутаас омно** хялбаршуулсан цахим www.tender.gov.mn/ ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2019 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 10 цаг 15 минутад** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.

Давуу эрх тооцоно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх утсаар авч болно.

Хөрөнгө удирдлагын хэлтэс, харилцах утас: 70078977